



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн нийцэл, газар олголт” сэдэвт аудитын тайланг нэгдүгээр, акт, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн Байнгын хороо, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд тус тус хүргүүлэх, холбогдох Байнгын хороонд танилцуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т даалгасугай.

3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам (Б.Бат-Эрдэнэ)-д зөвлөсүгэй.

4. Аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, аудитын тайлан, ажлын баримтыг 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газрын архивд шилжүүлэн ажиллахыг Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.

5. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын цахим хуудсанд ил тод байршуулахыг Захиргаа, хууль, эрх зүйн газар (С.Батбямба)-д үүрэг болгосугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч (Я.Сарансүх)-д даалгасугай.

Д.ЗАНДАНБАТ

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
ГРАФИК.....	2
ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	2
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ	4
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	6
АУДИТЫН ДҮН.....	8
НЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АЖЛЫН УЯЛДАА ХОЛБОО ХАНГАЛТГҮЙГЭЭС ТУСГАЙ	
ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ХИЛИЙН ЗААГИЙГ ТОГТООСОН УИХ-ЫН ТОГТООЛЫН	
ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА	8
ХОЁР. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛСЭН СӨРӨГ	
НӨЛӨӨЛЛИЙГ ҮНЭЛЖ, ДҮГНЭХ АЖЛЫГ БҮРЭН ХИЙГЭЭГҮЙ БАЙНА	12
ГУРАВ. БОГДХАН УУЛЫН ДЦГ-ЫН ХЯЗГААРЛАЛТЫН БҮСТЭЙ ДАВХЦУУЛАН УЛААНБААТАР	
ХОТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТАЛСАН БАЙНА.....	16
ДӨРӨВ. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖ, ТӨЛБӨРИЙН АКТ, АЛБАН ШААРДЛАГЫН БИЕЛЭЛТ	
БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА	27
БОАЖА-ААС ИРҮҮЛСЭН САНАЛ.....	28
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР.....	29
ДҮГНЭЛТ	30
ЗӨВЛӨМЖ.....	31
ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	32

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчлол	Тайлал
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БЦГ	Байгалийн цогцолборт газар
БНГ	Байгалийн нөөцийн газар
БДГ	Байгалийн дурсгалт газар
БОНБУТХ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар
ДЦГ	Дархан цаазат газар
НГЗБА	Нийслэлийн газар зохион байгуулалтын алба
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ОАТ	Онцгой албан татвар
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
ТХГНтХ	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
УТХГ	Улсын тусгай хамгаалалтын газар
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УУХҮС	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
ҮАГ	Үндэсний аудитын газар

ГРАФИК, ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Нэр
Зураглал 1	Монгол Улсын газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал
Зураглал 2	ТХГН-т газар ашиглуулах эрхийг авах үйл явц
Зураг 1	Тусгай хамгаалалттай газар нутаг /газар зүйн байршлаар/
Зураг 2	Богдхан уулын ДЦГ-ын хилийн заагийн зураглал
Зураг 3	Горхи-Тэрэлж БЦГ-ын хилийн заагийн зураглал
Зураг 4	Горхи-Тэрэлж БЦГ-т хэсэгчлэн чөлөөлсөн зураглал

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Дугаар	Нэр
Хүснэгт 1	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал, тоо хэмжээ
Хүснэгт 2	Тусгай хамгаалалтад авсан газар, түүний дотоод бүс
Хүснэгт 3	Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хилийн зааг
Хүснэгт 4	Богдхан уулын ДЦГ-ын талбайн хэмжээ
Хүснэгт 5	Тусгай хамгаалалттай газар нутгийг хөгжүүлэх менежментийн төлөвлөгөө
Хүснэгт 6	Хамгаалалтын захиргааны үүрэг гүйцэтгэж байгаа ТББ-уудын мэдээлэл
Хүснэгт 7	Тахийн тоо толгойн хөдлөл зүйн судалгаа
Хүснэгт 8	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн төвлөрүүлэлтийн орлого, зарлагын нэгтгэл
Хүснэгт 9	Төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээлэл
Хүснэгт 10	Богдхан уулын ДЦГ-ын хязгаарлалтын бүсэд үүссэн нөхцөл байдал
Хүснэгт 11	ТХГНтХ-ийн орон байр, барилга байгууламж барихтай холбоотой заалт
Хүснэгт 12	БОАЖЯ-аас тусгай хамгаалалттай газар ашиглах эрх олгосон мэдээлэл
Хүснэгт 13	Улсын хэмжээнд нийт тусгай хамгаалалттай газар олгосон мэдээлэл
Хүснэгт 14	Тусгай хамгаалалттай газарт газар олгосон Засаг дарга нарын шийдвэр
Хүснэгт 15	Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах гэрээний хэрэгжилт
Хүснэгт 16	Газрын төлбөр төвлөрүүлээгүй үлдэгдэл

Хүснэгт 17	Газрын нэгдсэн мэдээллийн санд бүртгэлтэй боловч гэрээний хугацаа дууссанаас нэхэмжлэл үүсээгүй иргэн, хуулийн этгээдийн тоо
Хүснэгт 18	Богдхан уул ДЦГ-т байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихтэй үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн жагсаалт
Хүснэгт 19	Улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй иргэн, хуулийн этгээдийн жагсаалт
Хүснэгт 20	Олон Улсын байгаль хамгаалах холбоо болон МУ-ын ТХГН-ийн ангилал, тодорхойлолт
Хүснэгт-21	Дэлхийн байгаль хамгаалах холбооны ТХГН-ийн засаглалын төрөл
Хүснэгт-22	Гадаад орны ТХГН-ийн нэвтрэх хураамжийн үнийг харьцуулсан байдал
Хүснэгт-23	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалыг тус тус үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилго:

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн нийцэл, үр нөлөө, газар олголт сэдэвт гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэнэ. Үүнд:

- Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хууль нь холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн акттай нийцэж байгаа эсэх
- Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт нь үр нөлөөтэй эсэх
- Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хууль тогтоомжийн дагуу газар олголт хийсэн эсэх
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад БОАЖЯ, ТХГН-ийн удирдлага түүний харьяа хамгаалалтын захиргаад, Богдхан уулын ДЦГ, Горхи-Тэрэлж БЦГ, Хөвсгөл нуурын УТХГ, ГЗБГЗЗГ, ТЕГ, АМГТГ зэрэг холбогдох төрийн эрх бүхий байгууллагуудын 2019-2022 оны 3 дугаар улирлын байдлаарх газар олголттой холбоотой шийдвэр, газар ашиглахтай холбоотой үйл ажиллагааг түүвэрлэн шалгасан болно. Мөн тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын үйл ажиллагаа, газар олголтыг сэргээсэн, цуцалсан, шүүхийн шийдвэрийн хүрээнд байгаа асуудал зэргийг түүвэрт хамруулаагүй болно.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос гаргасан АДБОУС 100, 300, 3000 стандартад нийцүүлэн баталсан дараах стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, Нийцлийн аудитын заавар, аргачлалыг ашиглав. Үүнд:

- Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”;
- MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”;
- MNS 6817-6:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим”;
- MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”.
- MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Хууль:

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль;
- Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль;
- Газрын төлбөрийн тухай хууль;
- Газрын тухай хууль;
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Иргэний хууль;

- Татварын ерөнхий хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль;
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль;
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль;
- Холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм журам.

Улсын Их Хурлын тогтоол:

- УИХ-ын 2019 оны “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” 41 дүгээр тогтоол;
- УИХ-ын 2020 оны “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, хилийн заагт өөрчлөлт оруулах тухай” 46 дугаар тогтоол;
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- УИХ -ын 2013 оны “Хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг батлах тухай” 23 дугаар тогтоол;

Засгийн газрын тогтоол:

- Засгийн газрын 1995 оны “Тусгай хамгаалалттай зарим нутгийн хамгаалалтын горим, хилийн цэсийг батлах” 169 дүгээр тогтоол;
- Засгийн газрын 2003 оны “Хураамжийн хэмжээг тогтоох тухай” 205 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2006 оны “Талбайн хэмжээг тогтоох тухай” 87 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2017 оны 287 дугаар тогтоолоор баталсан “Газрын улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах, түүний хэмжээ, заагийг тогтоох, ашиглах журам”;

Стандарт:

- Тусгай хамгаалалттай газар нутагт эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага. MNS 6426:2013 стандарт

Нийслэлийн ИТХТ-ийн тогтоол:

- Нийслэлийн ИТХТ-ийн 2015 оны “Нисэх Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөө” 198 дугаар тогтоол

Аудитын явцад гарсан хүндрэл, бэрхшээл

Аудитын горим стандартын дагуу эрсдэл тооцон улсын хэмжээнд тусгай хамгаалалттай газар нутгийн газар олголтын байдал, газрын маргаан үүсгэдэг хүчин зүйлс, шалтгаан нөхцөлийг тодруулахаар төлөвлөсөн.

Гэтэл Байгаль орчин, аялал, жуулчлалын яам, Татварын Ерөнхий газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын алба зэрэг байгууллагууд нь Land manager цахим программд газрын мэдээлэл оруулахдаа нэгж талбарын дугаар, газрын хэмжээ зэргийг зөрүүтэй оруулах, мэдээллийг бүрэн байршуулаагүйгээс тодорхой үйл ажиллагаа явуулахыг хуулиар хориглосон хамгаалалтын болон хязгаарлалтын бүсүүдэд газар олгосон зөрчлийг шалгахад шаардлагатай мэдээ, материал, судалгааг цуглуулж, боловсруулах, дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байлаа.


Мөн БОАЖЯ-ны дотоод газар, хэлтсүүд болон тус яамны харьяа УТХГН-ийн хамгаалалтын захиргаануудын ажлын чиг үүргийн давхардал, хийдэл, тэдгээрийн ажлын уялдаагүй, зохион байгуулалтгүй, хариуцлагагүй байдлаас нэгж талбарын хувийн хэрэг, баримт материалын бүрдэл дутуу, судалгаа, тайлан, тоон мэдээлэл зөрүүтэй байсан.

БОАЖЯ-ны тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны дарга холбогдох мэргэжилтнүүд ажлаас өөрчлөгдсөн, шинэ албан хаагчдын мэдлэг мэдээлэл дутагдалтай нь хүндрэл учруулж байлаа.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.” гэж, Газрын тухай хуулийн 9.1-д Монгол Улсын хилийн доторх бүх газар нь өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран газрын нэгдмэл сан мөн гэж заасан байна.

Зураглал 1. Монгол Улсын газрын нэгдмэл сангийн үндсэн ангилал / 2020 оны жилийн эцсийн байдлаар/



/Эх сурвалж: ГХГЗЗГ-ын мэдээлэл/

Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т “Газрын нэгдмэл сангийн аль ч ангиллын газраас улсын тусгай хэрэгцээнд авч болно.” гэж заасан бөгөөд Улсын тусгай хэрэгцээний газарт улсын тусгай хамгаалалттай газар хамаарч байна.

Зураг 1. Тусгай хамгаалалттай газар нутаг /газар зүйн байршлаар/



Тусгай хамгаалалттай газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах болон түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулах зорилго бүхий Тусгай хамгаалалттай газрын 30 хамгаалалтын захиргаа Улсын хэмжээнд нийт 32.7 сая.га буюу 120 газрыг 21 аймгийн нутаг дэвсгэрийг хамруулан хамгаалж байна.

Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсаж өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах, ашиглах, түүний унаган төрхийг хадгалах, хамгаалахтай холбогдсон харилцааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль болон бусад эрх зүйн актаар зохицуулж байна.

ТХГНтХ 1995 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээс хойш нийт 15 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Монгол Улс 1994 онд Нэгдсэн Үндэстний байгууллагын Байгаль орчны хөтөлбөр /UNEP/-аас баталсан Биологийн олон янз байдлын тухай конвенцод нэгдэн орсон бөгөөд Богдхан уулыг 1996 оны 5 дугаар сард ЮНЕСКО-оос Дэлхийн шим мандлын сүлжээнд оруулах шийдвэр гарч, 1997 онд гэрчилгээг олгосон байна.

Тус конвенцод зааснаар конвенцод нэгдэн орсон улс нь биологийн олон янз байдлыг хамгаалах нь нийт хүн төрөлхтний зорилт болохыг баталж, хүний зарим үйл ажиллагааны улмаас биологийн олон янз байдал үлэмж ядуурч, биологийн олон янз байдлыг үүсэж бий болсон унаган нутаг оронд нь хэвээр хадгалах арга хэмжээ авч биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой ашиглахыг тунхагласан байна.

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичигт Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 2025 онд 27 хувьд, 2030 онд 30 хувьд хүргэх зорилт дэвшүүлсэн байна.

ТХГНТХ-ийн 25 дугаар зүйлийн 2¹-т зааснаар УИХ нь Засгийн газрын өргөн мэдүүлснээр газар нутгийг тусгай хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, тэдгээр газрыг Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхой ангилалд хамааруулах, дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын хилийн заагийг батлах, өөрчлөх бүрэн эрхийг хэрэгжүүлж байна.

Хүснэгт 1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал, тоо хэмжээ

№	Ангилал	Талбайн хэмжээ /сая.га/	Газар нутгийн хэмжээ /хувь/	Хамгаалалтад авсан газрын тоо
1	Дархан цаазат газар	13.8	8.8	14
2	Байгалийн цогцолборт газар	13.5	8.6	47
3	Байгалийн нөөц газар	5.3	3.4	37
4	Дурсгалт газар	0.1	0.1	22
	Нийт	32.7	21	120

/Эх сурвалж: Байгаль орчин аялал, жуулчлалын яам/

Манай орны нийт газар нутгийн 21 хувь буюу 32.7 сая.га талбайг тусгай хамгаалалттай газар нутаг эзэлж байна.

ТХГНТХ-ийн 3 дугаар зүйлийн 2²-т заасны дагуу аймаг, нийслэлийн ИТХ-ын шийдвэрээр 1438 байршил бүхий 24.8 сая га.талбай буюу нийт газар нутгийн 15.8 хувийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч, хилийн заагийг тогтоосон байна.

¹ Засгийн газрын өргөн мэдүүлснээр газар нутгийг тусгай хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, эдгээр газрыг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхой ангилалд хамааруулах, дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын хилийн заагийг батлах, өөрчлөх.

² “Аймаг өөрийн нутаг дэвсгэрт байгаа тодорхой газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч болно.”

АУДИТЫН ДҮН

НЭГ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АЖЛЫН УЯЛДАА ХОЛБОО ХАНГАЛТГҮЙГЭЭС ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ХИЛИЙН ЗААГИЙГ ТОГТООСОН УИХ-ЫН ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

1.1 ТХГНТХ-ийн 25 дугаар зүйлийн 2-т “Засгийн газрын өргөн мэдүүлснээр газар нутгийг тусгай хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, эдгээр газрыг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхой ангилалд хамааруулах, дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын хилийн заагийг батлах, өөрчлөх.” гэж заасны дагуу УИХ ДЦГ болон БЦГ-ын хилийн заагийг тогтоож байна.

Хүснэгт 2. Тусгай хамгаалалтад авсан газар, түүний дотоод бүс /2022 оны 12 сарын байдлаар/

Ангилал	Газрын тоо	Нийт хэмжээ /сая.га/	Ангилал	сая.га
Дархан цаазат газар	22	13.8	Онгон бүс	2.6
			Хамгаалалтын бүс	5.2
			Хязгаарлалтын бүс	5.9
Байгалийн цогцолбор газар	37	13.4	Онцгой бүс	1.8
			Аялал жуулчлалын бүс	5.5
			Хязгаарлалтын бүс	6.1

/Эх сурвалж: Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газар. www.eic.mn/

1.2 ТХГНТХ-ийн 26 дугаар зүйлийн 6⁴-д зааснаар Байгалийн нөөц болон дурсгалт газрыг Улсын тусгай хамгаалалтад авч хилийн заагийг Засгийн газар тогтоож байна. Байгалийн нөөц газарт 47 байршилд 5.4 сая.га, Байгалийн дурсгалт газарт 14 байршилд 0.1 сая.га нийт 5.5 сая.га талбай хамарсан байна.

1.3 УИХ-ын 2019 оны 41, 2020 оны 46 дугаар тогтоолоор нэр бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авахаар шийдвэрлэж, хилийн заагийг тогтоохыг Засгийн газарт даалгасан байна.Үүнд:

Хүснэгт 3. Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хилийн зааг /га-аар/

№	Нэр	Ангилал	Аймаг	УИХ баталсан
УИХ-ын 2019 оны 41 дүгээр тогтоол				
1	Цагаан дэлийн агуй	БДГ	Дорноговь	116.01
2	Улз гол	БНГ	Хэнтий	102,526.98
3	Зотол хаан уул	БНГ	Сүхбаатар	42,628.50
4	Ташгай таван нуур	БНГ	Дорнод	155,177.67
5	Дэлгэрхаан уул	БНГ	Хэнтий	48,447.15
6	Дулаан хайрхан	БНГ	Өвөрхангай	39,034.70
7	Гүн гашууны хоолой	БНГ	Дорноговь	141,318.72
8	Халх таван уул	БНГ	Дорнод	99,464.02
9	Хөх нуур	БНГ	Дорнод	94,779.2
10	Жаран тогооны тал Б	БНГ	Дорнод	91,095.29
11	Мэнэнгийн цагаан хоолой	БНГ	Дорнод	45,748.46
12	Баяндун уул	БНГ	Дорнод	53,020.78
13	Сутай уул	БНГ	Говь-Алтай, Ховд	172,713.32
14	Жаран тогооны тал А	БНГ	Дорнод	97,514.16
15	Онгон таван булаг	БНГ	Сүхбаатар	155,911.61
Дүн				1,339,496.57
УИХ-ын 2020 оны 46 дугаар тогтоол				
1	Баянхонгор хайрхан	БНГ	Баянхонгор	2,368.97
2	Алтан хөхий уул	БНГ	Ховд	113,803.72
3	Хурх хүйтний хөндий	БНГ	Хэнтий	193,592.58
4	Хөх нуур бумбат	БНГ	Баянхонгор	206,467.69
Дүн				516,232.96
Нийт дүн				1,855,729.53

⁴ Байгалийн нөөц газрын болон дурсгалт газрын хилийн заагийг тогтоох.

1.4 Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээг тогтоохдоо БОАЖЯ нь нарийвчилсан судалгаа хийгээгүй, УУХҮЯ, ГЗБГЗЗГ, АМГТГ зэрэг байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, мэдээллийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд тухай бүр бүртгэж оруулаагүйгээс УИХ-ын тогтоолоор тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хилийн заагийг тогтооход хүндрэл учирсан байна.

1.5 УИХ-ын 2019 оны 41 дүгээр тогтоолд заасан тусгай хамгаалалтад авах газар нутагт газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөлтэй давхцал бүхий дараах газрууд байгааг УУХҮС-ын 2022 оны 01/2992 дугаартай албан бичигт дурдсан байна. Үүнд:

- *Улз голын эхийн байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоох талбайн солбицол нь XV-020535 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий 27.09 га талбайтай хэсэгчлэн, MV-016940 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 36.77 га талбайтай хэсэгчлэн,*
- *Зотол хаан уулын байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоох талбайн солбицол нь газрын тосны ашиглалтын бүтээгдэхүүн хуваах гэрээт Матад XX буюу 420565,31 га талбайтай бүхэлдээ,*
- *Халхын таван уул байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоох талбайн солбицол нь газрын тосны хайгуулын бүтээгдэхүүн хуваах гэрээт Хөх нуур XVIII талбайтай бүхэлдээ,*
- *Хөх нуурын байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоох талбайн солбицол нь Хөх нуур XVIII буюу 54,330.21 га талбайтай хэсэгчлэн,*
- *Жаран тогооны тал “Б” хэсгийн байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоох солбицол нь газрын тосны хайгуулын бүтээгдэхүүн хуваах гэрээт Хэрлэн тохой XXVIII буюу 55,329.41 га талбайтай болон Давст XXXI буюу 34,620.58 га талбайтай хэсэгчлэн,*
- *Сутай хайрхан уулын байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоох талбайн солбицол нь газрын тосны хайгуулын бүтээгдэхүүн хуваах гэрээт Шарга III буюу 96,026.2 га талбайтай хэсэгчлэн,*
- *Жаран тогооны тал “А” хэсгийн байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоох талбайн солбицол нь газрын тосны хайгуулын бүтээгдэхүүн хуваах гэрээт Хэрлэн тохой XXVIII буюу 94,087.07 га талбайтай хэсэгчлэн,*
- *Онгон таван булаг байгалийн нөөц газрын хилийн заагийг тогтоох талбайн солбицол нь газрын тосны хайгуулын бүтээгдэхүүн хуваах гэрээт Дарьганга XXIV талбайтай бүхэлдээ тус тус давхцалтай байна.*

1.6 Түүнчлэн УИХ-ын 2020 оны 46 дугаар тогтоолд заасан тусгай хамгаалалтад авах газар нутагт газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 7 ашигт малтмалын зөвшөөрөл давхцалтай байсныг арилгасан боловч дахин санал авахад дараах газрууд давхцалтай байгааг УУХҮС-ын 2022 оны 01/2993 дугаартай албан бичигт дурдсан байна. Үүнд:

- *Алтан хөхий уулын БНГ-ын хилийн заагийг тогтоох талбайн солбицол нь XV-021743 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий 4289.75 га талбайтай хэсэгчлэн, газрын тосны хайгуулын бүтээгдэхүүн хуваах гэрээт Хар ус II талбайтай бүхэлдээ давхцалтай байна.*

1.7 УИХ-ын 2019 оны 41 дүгээр, 2020 оны 46 дугаар тогтоол гаргах үед 478 өвөлжөө, хаваржаа давхцалтай байсан бол хилийн заагийг тогтоогоогүйгээс 758 болон нэмэгдэж, ТХГНТХ-ийн 21 дүгээр зүйлийн 2-т “мал аж ахуй эрхлэгч малчин өрхөд өвөлжөө, хаваржааны газар олгох ...хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

1.8 АМГТГ-ын 2022 оны 10/3958 дугаартай албан бичгээр УТХГ-тай давхцалтай ашигт малтмалын дараах тусгай зөвшөөрөл байгааг дурдсан байна. Үүнд:

- *Ноён уулын дархан цаазат газрын хилийн гадна орчны бүсэд Пураам ХХК-д 7.88 га, Гацуурт ХХК 127.21 га, Сонгоулд ХХК 2557.86 га, Лучеро ХХК 189.54 га газар;*
- *Зэд-Хантай-Бүтээлийн нурууны хамгаалалтын бүсэд байгаа орчны бүсэд Монресор сиз ХХК 1772.63 га, Шарнарст ХХК 259.55 га, Микмайнинг ХХК 90 га газар;*
- *Их газрын чулуу БЦГ-т Шарлангол ХХК 588.48 га, Гурвансайхан хамтарсан хөрөнгө оруулалттай ХХК 2415.78 га газар;*
- *Тосон хулстай Байгалийн нөөц газарт Баян-Эрдэс ХХК 76.68 га, Адуляргео ХХК 218.81 га газар;*

1.9 Ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Хүчин төгөлдөр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн тусгай хэрэгцээнд авснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмал эрэх,

хайх, ашиглах боломжгүй болсон бол тухайн шийдвэр гаргасан байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговрыг нэг жилийн дотор төлнө” гэж заасан.

1.10 Гэвч Засгийн газрын эрх олгосны дагуу Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан талбайг улсын тусгай хамгаалалтад авсан тохиолдолд гэрээлэгчдийн үйл ажиллагаандаа зарцуулсан хөрөнгө оруулалтыг буцаан олгох, нөхөн олговрыг шийдвэрлэхэд улсын төсвөөс ихээхэн хэмжээний хөрөнгө гарах эрсдэлтэй байна.

Богд хан Уулын ДЦГ-ын хилийн зааг, цэгүүдийн холболтын зураг хийгээгүй, төрийн эрх бүхий байгууллагууд тус бүрдээ зураглал хийсэн нь хилийн давхцал бий болгож байна

Богд хан Уулын дархан цаазат газар

1.11 АИХ /хуучин нэрээр/-ын Тэргүүлэгчдийн 1988 оны 78 дугаар зарлигаар Богдхан уулын хилийн заагийг анхлан тогтоосон ба УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Богдхан уулын ДЦГ -ын хилийн заагийг Айц уул /1735.2/ гэж тогтоосон бөгөөд хилийн заагийн эргэлтийн цэгүүдийг нарийвчлан зураглаж, солбицлын цэгээр тодорхойлж, тэмдэгжүүлээгүй байна.

1.12 УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоолын дагуу ГЗБГЗЗГ-ын даргын 2019 оны А/65 тушаалаар 1:50000 масштабтай зураглал хийсэн боловч эрх бүхий байгууллагын тушаал шийдвэрээр баталгаажуулаагүй байна.

1.13 Богдхан уулын ДЦГ-ын хилийн заагийг Төрийн эрх бүхий байгууллагууд дараах байдлаар зурагласан байна.Үүнд:


Хүснэгт 4. Богдхан уулын ДЦГ-ын талбайн хэмжээ

№	Нэрс	Зураглал хийсэн байгууллага	Огноо	Га.талбай	БОАЖЯ-ны зураглалаас зөрүүтэй
1	ЮНЕСКО-д бүртгэсэн талбай		1997	41,650.0	-
2	БОАЖЯ-ны зураглал	ГХГЗЗГ /хуучин нэр/	2011	42,192.4	-542.4
3	НГЗБА-ны зураглал	НГЗБА	2012	41,089.4	560.6
4	УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоолын дагуу	ГЗБГЗЗГ-ын даргын 2019 оны А/65	2019	41,423.4	226.6

/Эх сурвалж: БОАЖЯ/

1.14 Хамгийн сүүлд ГЗБГЗЗГ-ын даргын 2019 оны А/65 тушаалаар зурагласан 41,423.4 га талбайн зураглал нь ЮНЕСКО олон улсын байгууллагад бүртгүүлсэн 41,650.0 га талбайгаас 226.6 га-аар буурсан байна.


Зураг 2. Богдхан уулын ДЦГ-ын хилийн заагийн зураглал



Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газар

1.16 УИХ-ын 1993 оны 83 дугаар тогтоолоор Туул голын эх, Хэнтийн нурууны өвөр хэсгийг хамарсан Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрыг Улсын тусгай хамгаалалтад авч, 1995 оны 26 дугаар тогтоолоор хилийн заагийн солбицлыг тогтоосон ба 2022 оны байдлаар нийт 293,041 га талбай бөгөөд үүний 29,495 га нь Налайх дүүргийн нутаг, 263,546 га нь Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт хамаардаг байна.

Зураг 3. Горхи-Тэрэлж БЦГ-ын хилийн заагийн зураглал



Зураг 4. Горхи-Тэрэлж БЦГ-т хэсэгчлэн чөлөөлсөн зураглал



1.17 УИХ-ын 2012 оны 38 дугаар тогтоолоор Богдхан уулын ДЦГ-ын хязгаарлалтын бүс дэх Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны Төмөр замын Туул зөрлөгийн 33.5 га, Хан-Хэнтийн тусгай хамгаалалттай газрын Горхи-Тэрэлжийн БЦГ дахь Налайх дүүргийн 6 дугаар хороо Тэрэлжийн төв сууринд байрлах 222.5 га, Тэрэлжийн шугуйд 40 га газрыг тус тус тусгай хамгаалалттай газар нутгаас чөлөөлсөн байна.

1.18 УИХ-ын бүрэн эрхэд хамаарахгүй “чөлөөлөх” шийдвэрийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр гаргасан нь ТХГНТХ-ийн 25 дугаар зүйлийн 2-т “... дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын хилийн заагийг батлах, өөрчлөх.” гэсэн заалтыг үндэслэсэн байна.

1.19 Горхи-Тэрэлжийн БЦГ-ын Дуган цагаан гэдэг газарт Төв аймгийн Эрдэнэ сумын Баянтуул багийг Эрдэнэ сумын ИТХ-ын 2004 оны 10 дугаар тогтоолоор байгуулж, 2015 оны 04 дүгээр тогтоолоор “Баянтуул” багийн тэг гортигийг 2009 га-аар тогтоож, газар олгож эхэлсэн байна.

1.20 ТХГН-ийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 2014 оноос 2018 оны хооронд Төв аймгийн Засаг дарга 2 удаа, ИТХ-ын дарга 2 удаа, Төв аймгийн Эрдэнэ сумын Засаг дарга 2 удаа, ИТХ-ын дарга 2 удаа, мэргэжлийн хяналт, Төв аймгийн газрын харилцаа, геодези, зураг зүйн газар, захиргааны хэргийн анхан шатны шүүх зэрэг байгууллагуудад хууль бус газар олголтын талаар удаа дараа мэдэгдэж байсан байна.

1.21 Гэвч Эрдэнэ сумын Засаг даргын захирамжаар 2002-2022 онуудад нэр бүхий 370 иргэн, хуулийн этгээдэд 458.2 га газар эзэмших, нэр бүхий 1169 иргэн, хуулийн этгээдэд 317.9 га газар өмчлөхөөр олгосон талаар ГЗБГЗЗГ-ын нэгдсэн мэдээллийн санд бүртгэлтэй байна.

Хөвсгөлийн байгалийн цогцолбор газар

1.23 БНМАУ-ын Бага Хурлын 1992 оны “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авахыг зөвшөөрөх тухай” 11 дүгээр тогтоолоор тусгай хамгаалалтад авч УИХ-ын 1995 оны

26 дугаар тогтоолоор Хөвсгөл нуур, түүний сав газар, Цагаан-Үүр-Уйлганы орчмын зарим газар нутгийг хамарсан Хөвсгөлийн БЦГ-ын хилийн заагийг тогтоосон байна.

1.24 УИХ-ын 2011 оны 18 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар хилийн заагийг шинэчлэн тогтоож, Хөвсгөлийн БЦГ-ын хилийн заагаас Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгон болон Ханх сумын төвийн эдэлбэр газрыг тус тус чөлөөлсөн байна.

1.25 Мөн УИХ-ын 2019 оны 41 дүгээр тогтоолоор Хөвсгөл аймгийн Цагаан-Уул, Цэцэрлэг, Шинэ-Идэр, Бүрэнтогтох сум, Завхан аймгийн Тэлмэн, Их-Уул сумын нутгийг дамнан орших Тэсийн гол, Булнайн нурууг БЦГ-ын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авч 2020 оноос хойш Хөвсгөлийн тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа хариуцан ажиллаж байна.

ХОЁР. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛСЭН СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ ҮНЭЛЖ, ДҮГНЭХ АЖЛЫГ БҮРЭН ХИЙГЭЭГҮЙ БАЙНА

2.1 УИХ-ын 1998 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрт”-т Тусгай хамгаалалттай газар нутаг бүр өөрийн үйл ажиллагааны урт, богино хугацааны зорилтыг тодорхойлсон менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэхээр заасан байдаг.

2.2 Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2021 оны А/16 дугаар тушаалаар “Менежментийн төлөвлөлтийн арга зүй”-г шинэчлэн баталж, тусгай хамгаалалттай газар нутагт менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5 Тусгай хамгаалалттай газар нутгийг хөгжүүлэх менежментийн төлөвлөгөө

№	Ангилал	Тоо	Менежмент төлөвлөгөө		
			Төлөвлөгөө хэрэгжиж буй	Төлөвлөгөөний хугацаа дууссан	Төлөвлөгөөгүй
1	Дархан цаазат газар	22	14	9	2
2	Байгалийн цогцолборт газар	37	15	14	5
3	Байгалийн нөөц газар	47	19	1	27
4	Байгалийн дурсгалт газар	14	2	2	10
	Бүгд	120	50	26	44

/Эх сурвалж : Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газар/

2.3 Тусгай хамгаалалттай нийт 120 газар нутгийн 50 нь менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлж ажилласан боловч 26 нь төлөвлөгөөний хугацаа дууссан, дахин боловсруулаагүй, 44 нь ямар ч төлөвлөгөөгүй ажиллаж байна.

2.4 Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/374 дүгээр тушаалаар баталсан “Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээний аргачлал”-д менежментийн төлөвлөгөөнд хамгаалахаар сонгосон үнэт зүйлийн төлөв байдлыг тодорхойлж, өмнөх түвшинтэй харьцуулан дүгнэнэ гэж заасны дагуу аудитын хамрах хугацаанд нийт 29 тусгай хамгаалалттай газар нутагт менежментийн үр ашигт байдлын үнэлгээг хийлгэснээс 50 хувиас доош үнэлгээтэй 7 газар байна.

2.5 БОАЖЯ-ны тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх, бодлого боловсруулах, хэрэгжилтийг хангах, Улсын тусгай хамгаалалттай бүс нутгуудын хамгаалалтын захиргаануудын менежментийн төлөвлөгөөг олон улсын туршлага, өөрийн орны онцлогт тохируулан боловсруулж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, удирдлага арга зүйгээр хангах чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд зарим тусгай хамгаалалттай газар нутагт ТББ-аар хамгаалалтын захиргааны үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна.

2.6 Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1¹⁰-д, ТХГНТХ-ийн 26 дугаар зүйлийн 2¹¹-т заасны дагуу тусгай хамгаалалттай газрыг Засгийн газрын бус байгууллагаар бүтэн буюу хэсэгчилсэн байдлаар хамгаалуулах, ашиглуулах үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр заасан байна. 2022 оны байдлаар дараах ТББ-ууд хамгаалалтын захиргааны чиг үүргийг гүйцэтгэн ажиллаж байна. Үүнд:
Хүснэгт 6 Хамгаалалтын захиргааны үүрэг гүйцэтгэж байгаа ТББ-уудын мэдээлэл

№	ТХГН-ийн нэр	Хамгаалалтын захиргаа	Огноо	Байршил	Нийт талбай (га)	2020 он сая.төг	Санхүү жилт
1	Хустайн БЦГ	Хустай цогцолборт газар ТББ	1994	Төв аймгийн Аргалант, Алтанбулаг, Баянхангай сумдын зааг	48,889.00	1,200.0	Хустай цогцолборт газар ТББ
2	Хомын талын БЦГ	Хомын талын тахь ТББ	2020	Завхан аймгийн Дөрвөлжин сумын Онц болон Таван толгой баг	411,403.82	2,000.0	Ролекс сан
3	Их нартын БНГ	Аргаль, агнуур судалгааны төв ТББ	2013	Дорноговь аймаг Айраг, Даланжаргалан сум	66,591.74	80.0	Их нартын менежмент ТББ
		Их нартын менежмент ТББ	2019				
4	Хар ямаатын БНГ	Дэлхийн байгаль хамгаалах сан ТББ	2013	Хэнтий аймгийн Баян-Овоо, Сүхбаатар аймгийн Түмэнцогт сум	50,690.90	260.0	Дэлхийн байгаль хамгаалах сан
5	Тост, Тосон бумбын нурууны БНГ	Ирвэс хамгаалах сан ТББ	2019	Өмнөговь аймаг Гурван тэс сум	40,270.50	84.2	Орон нутгийн төсвөөс

/Эх сурвалж :Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газар/

2.7 Хувийн хэвшилд тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны эрхийг шилжүүлснээр тухайн газар нутгийн хамгаалалт сайжрах, ховор амьтныг өсгөн үржүүлэх, аялал жуулчлалын чиглэлээр тодорхой төлбөртэй үйлчилгээ үзүүлж, өөрөө өөрийгөө санхүүжүүлж байна.

2.8 УИХ-ын 1993 оны 83 дугаар тогтоолоор Хустайн нурууг БНГ-ын ангиллаар анх улсын хамгаалалтад авч, 1998 онд ангиллыг ахиулж БЦГ болгож, анхны менежментийн төлөвлөгөөг 2001 онд батлуулан хэрэгжүүлснээс хойш 5 дахь менежментийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна.

2.9 Тус хамгаалалтын захиргаа хамгаалах үнэт зүйл буюу тахийг хамгаалж, үржүүлэн аудитын хамрах хугацаанд 33.4 хувиар өсгөсөн байна.

Хүснэгт 7 Тахийн тоо толгойн хөдлөл зүйн судалгаа

№	Хустайн БЦГ	2019 он	2020 он	2021 он	2022 он	Өсөлтийн хувь
1	Тахийн тоо толгой	276	293	349	415	33.4%

/Эх сурвалж: ТХГН-ийн үнэт зүйлийн төлөв байдлын судалгаа/

2.10 Төрийн бус байгууллагуудын хариуцан ажиллаж буй хамгаалалтын захиргаад судалгаанд суурилсан байгаль хамгааллын төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа нь ирээдүйд гарах эрсдэлийг тооцож, эрдэм шинжилгээний байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж байна. Тухайлбал:

¹⁰ Засгийн газар нь төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг холбогдох хууль, түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлж болно.

¹¹ тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах эдийн засаг, зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлж энэ асуудлаар Засгийн газрын болон Засгийн газрын бус байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах;

- Хустайн цогцолборт газар ТББ нь ШУА-ийн Биологийн хүрээлэн, Ботаникийн хүрээлэн, Археологийн хүрээлэн, Геоэкологийн хүрээлэн, МУИС, МУБИС, ХААИС зэрэг шинжлэх ухааны байгууллагуудтай, түүнчлэн Голландын Вахенингийн, Японы Цукуба, Окаямагийн их сургууль, АНУ-ын Смитсоны хүрээлэн, Английн Зэрлэг амьтан судлалын нийгэмлэгтэй хамтран ажиллаж байна.

2.11 УИХ-ын 2020 оны 46 дугаар тогтоолоор Хомын тал орчим 411,403.80 га талбай бүхий газар нутгийг БЦГ-ын ангиллаар улсын тусгай хамгаалалтад оруулан Хомын талын тахь нийгэмд үйлчлэх ТББ хамгаалалтыг хариуцан ажиллаж байна.

2.12 ТХГН-ийн хамгаалалтын захиргааны үүргийг Байгаль орчныг хамгаалах тухай хууль 32 дугаар зүйлийн 32.2¹² -д заасны дагуу ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1¹³-д заасны дагуу тусгай хамгаалалтай газар нутгаас ашигласан нөөцийн төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр тооцож орон нутгийн төсвөөс авах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг алдсан байна

2.13 Улсын тусгай хамгаалалттай 120 газрыг 34 хамгаалалтын захиргаа хариуцан ажилладаг бөгөөд 2022 оны байдлаар нийт 8717 иргэн, 265 хуулийн этгээдэд хяналт шалгалт хийж давхардсан тоогоор 469 зөрчил илрүүлж, 109.9 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 375 зөрчил арилгах албан шаардлага өгч, 21097 иргэн, 427 хуулийн этгээдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан байна.

2.14 Нийт 30 хамгаалалтын захиргаанд Улсын төсвөөс 2021 онд 10,989.6 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, гүйцэтгэлээр 10,762.5 сая төгрөг буюу 97.9 хувийг зарцуулжээ. Хамгаалалтын захиргааны санхүүжилтийн 70 гаруй хувийг цалин хөлсөнд, 30 орчим хувийг бусад зардалд зарцуулж байна.

2.15 Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалах ажлын төсвийг байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг нөхөн сэргээх, газрыг засаж тохижуулах арга хэмжээг хэрэгжүүлэх, судалгаа шинжилгээ хийх, сурталчлах зардал болон ажиллагсдын цалин хөлс зэрэгт зарцуулахаар хуульчилсан байна.

2.16 Санхүүжилтийн 90 орчим хувь нь улсын төсвийн санхүүжилтээр, 10 орчим хувь нь аялал жуулчлалын болон бусад ажил, үйлчилгээний орлого буюу тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэн орох хураамжийн орлогоос бүрддэг байна.

2.17 Байгаль орчны сайдын 2002 оны 117 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар ТХГН-т түр нэвтрэн ороход иргэнээс төлөх төлбөрийн хэмжээг гадаадын иргэнээс 3000 төгрөг, Монгол Улсын иргэн тус тарифын 10%-тай тэнцэх хөлсийг төлөхөөр тогтоосон бөгөөд 20 гаруй жилийн өмнө тогтоосон тус тарифыг одоог хүртэл мөрдөж байна. Одоогийн байдлаар иргэнээс хураан авч буй 300 төгрөг нь тасалбарын зардлаа нөхөхгүй болсон байна.

2.18 Хамгаалалтын захиргааны үйл ажиллагаа, нутаг дэвсгэрийг хамгаалахад Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1¹⁴-д заасны дагуу тооцвол байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжтой байна. Үүнд:

¹² Засгийн газар байгаль орчныг хамгаалах талаархи төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллагад эсхүл тухайн нутгийн иргэдийн сайн дурын үндсэн дээр нээгдэн байгуулагдсан этгээдэд шилжүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болно.

¹³ Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

¹⁴ Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

Хүснэгт 8 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн төвлөрүүлэлтийн орлого, зарлагын нэгтгэл

№	Байгалийн нөөцийн төрлүүд	Төвлөрүүлсэн орлого /сая төгрөг/					
		2019 он		2020 он		2021 он	
		Төсөвт төвлөрсөн орлого	Зарцуулбал зохих	Төсөвт төвлөрсөн орлого	Зарцуулбал зохих	Төсөвт төвлөрсөн орлого	Зарцуулбал зохих
1	Газрын нөөц ашигласны төлбөр /15%/	35,699.0	5,354.8	49,468.5	7,420.3	68,585.1	10,287.8
2	Ойн нөөц ашигласны төлбөр /85%/	3,608.9	3,067.6	12,279.0	10,437.1	14,092.2	11,978.4
3	Ан, амьтны нөөцийн төлбөр /50%/	7,227.3	3,613.6	1,164.1	582.0	13,767.1	6,883.6
4	Байгалийн ургамлын нөөцийн төлбөр/15%/	198.5	29,775.0	7,066.2	1,059.9	4,003.9	600.6
5	Усны нөөцийн төлбөр /35%/	47,137.1	16,498.0	42,151.5	14,753.0	48,159.2	16,855.7
	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын дүн	93,870.8	28,563.8	112,129.3	34,252.4	148,607.5	46,606.0
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулсан зардал		12,374.6		13,126.4		12,206.7
	Хуулийн хэрэгжилтийн хувь		44.7		38.3		26.2

/Эх үүсвэр: БОАЖЯ-ны тайлангаас/

2.19 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлого жил бүр 10-13 хувиар нэмэгдэж байгаа боловч зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэх нь тодорхойгүй, тухайн төсвийн жилд орон нутгийн төсөвт төвлөрсөн орлогоос хуульд заасны дагуу хамгаалах болон нөхөн сэргээх зардалд заасан хувиар санхүүжүүлээгүй байна.

2.20 ТХГН-ийн хамгаалалтын захиргаа байгаль, амьтан, ургамал хамгаалах, байгаль орчныг нөхөн сэргээх талаарх судалгаанд суурилсан төлөвлөлт хийж, орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллах шаардлагатай байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт хэрэгжиж буй зарим төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна

2.21 ТХГН-т 2022 оны байдлаар дараах гадаадын төсөл, хөтөлбөр хэрэгжиж байна. Үүнд:

Хүснэгт 9 Төсөл, хөтөлбөрийн талаарх мэдээлэл

№	Төслийн нэр	Санхүүжүүлэгч байгууллага	Хугацаа /он/	Санхүүжилт /сая/	Хэрэгжилт
1	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл	ХБНГУ	2015-2021	15.3 /евро/	Төслийн хүрээнд хамгаалалтын захиргаануудад барилга, автомашин, тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна.
2	ТХГН-ийн экосистемийг хадгалан хамгаалахад хувь нэмэр оруулах нь "SPACES" төсөл	ХБНГУ	2019-2022	4.5 /евро/	Эрх зүйн орчныг сайжруулах, сургалт, сурталчилгааны стратеги боловсруулах ажлуудыг хийсэн байна.
3	Дорнод Монголын хуурай тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал төсөл	Дэлхийн байгаль хамгаалах сан	2021-2025	5.3 /ам.доллар/	Хэнтий, Сүхбаатар аймгийн зарим сумдад газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулж байна.

/Эх үүсвэр: БАӨЖЯ/

2.22 Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн хүрээнд худалдан авсан 93.1 сая төгрөгийн Тоёото ланд круйзер автомашин эзэмших гэрчилгээ ТББ-ын нэр дээр бүртгэлтэй мөн 110.0 сая төгрөгийн дизель хөдөлгүүрийг БОАЖЯ-ны санхүүгийн тайланд бүртгээгүй байна.

2.23 ТХГН-ийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийн болон үр дүнг тооцож, хэрэгжилтэд хяналт тавьж, төсөл хэрэгжүүлэгч нэгжийг бодлого арга зүйгээр хангаж ажиллах шаардлагатай байна.

ГУРАВ. БОГДХАН УУЛЫН ДЦГ-ЫН ХЯЗГААРЛАЛТЫН БҮСТЭЙ ДАВХЦУУЛАН УЛААНБААТАР ХОТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨГ БАТАЛСАН БАЙНА

Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын Биологийн олон янз байдлын тухай конвенцын зорилтыг хангаж чадахгүй нөхцөл байдал үүссэн байна

3.1 Монгол Улсын нэгдэн орсон Биологийн олон янз байдлын тухай конвенцын 6²¹ дугаар зүйлд заасан биологийн олон янз байдлыг хамгаалах талаар зорилтын заалт, ТХГНтХ-ийг зөрчиж УИХ-ын болон Нийслэлийн ИТХ-ын тогтоол баталсан байна. Үүнд:

Хүснэгт 10 Богдхан уулын ДЦГ-ын хязгаарлалтын бүсэд үүссэн нөхцөл байдал

Шалгуур		
Биологийн олон янз байдлын тухай конвенци	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль	
Хамгаалах, тогтвортой ашиглах талаар хэрэгжүүлэх ерөнхий арга хэмжээ. Хэлэлцэн тохиролцогч Талууд өөрсдийн тодорхой нөхцөл, бололцоондоо нийцүүлэн дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд: 6.а)биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой ашиглах талаар үндэсний бодлого, хэтийн чиглэл, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах эсхүл энэхүү Конвенцид туссан, холбогдох Хэлэлцэн тохиролцогч Талуудад хамаатай арга хэмжээнүүдийг илэрхийлж буй одоо баримталж байгаа бодлого, хэтийн чиглэл, төлөвлөгөө, хөтөлбөрөө зохицуулан өөрчлөх, б)биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой ашиглах арга хэмжээнүүдийг холбогдох салбар, салбар хоорондын төлөвлөгөө, хөтөлбөр, бодлогод аль болохоор тусгах.	11 дүгээр зүйлийн 11.7-д "аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах", 12 дугаар зүйлийн 12.5-д "энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 7-д зааснаас өөр барилга байгууламж барих" гэж заасны дагуу Дархан цаазат газрын аль ч бүсэд "аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байр"-ыг ашиглахаас бусад зориулалтаар газар ашиглахыг хориглосон.	33 дугаар зүйлийн 33.1-т "Дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой зориулалт, хугацаа, болзолтойгоор байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр ээрээний үндсэн дээр ашиглуулж болно" гэж заасан.
Нөхцөл байдал		
УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоол	НИТХ-ын 2015 оны 198 дугаар тогтоол	Стандартчиллын үндэсний зөвлөл 2013 оны 60 дугаар тогтоол
"Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг"-т 1.Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг хавсралтад заасан бүрдэлтэйгээр баталсугай. 2.Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийг мөрдөхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт үүрэг болгосон байна.	Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөг баталж, түс төлөвлөгөөнд Хан-Уул дүүргийн 4-10, 16 дугаар хорооны нутаг дэвсгэрийг хамруулсан нь БХУДЦГ-ын хязгаарлалтын бүсийг хамруулсан байна. Энэ нь Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т заасан "хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн хот, тосгоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлах" бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ТХГНтХ-ийн 12 дугаар зүйлд заасан дархан цаазат газар хориглох үйл ажиллагааг зөрчсөн тогтоолыг гаргасан байна.	Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц. Үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага" MNS6426:2013 стандартыг баталж 5.3.3-т "Байр сууц, байгууламж нь аялал жуулчлалын бүтээгдэхүүний үндсэн шинж чанарыг хадгалсан, тухайн орчны байгаль ландшафтын дүр төрхөд нийцсэн, түүхийн соёлын өвийг хүндэтгэсэн хийц загвартай байх ба барилгын газар дээрх давхар хоёр давхраас өндөргүй байна" гэж заасан байна. Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 50 дугаар тогтоолоор стандартын дээрх шаардлагыг өөрчилж "Нийслэлийн төвийн дүүргийн нутаг дэвсгэрт хамаарагдах тусгай хамгаалалттай газар нутгийн хил зааг дахь суурин газрын бүсийн ерөнхий төлөвлөгөөний дагуу барилга, байгууламжид дээрх давхрын өндрийн хязгаарлалт хамаарахгүй" гэж нэмэлт өөрчлөлт оруулсан.
Үр дагавар		
УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоол, НИТХ-ын 2015 оны 198 дугаар тогтоол, СҮЗ-ын MNS6426:2013 стандартад 2015 онд орсон нэмэлт өөрчлөлтөөр БХУДЦГ-ын хязгаарлалтын бүсэд иргэн, ААН, байгууллагад олон давхар орон сууц, хувийн хаус, албан газрын барилгууд баригдах боломжийг бүрдүүлж 2022 оны байдлаар амины орон сууц 2207, нийтийн орон сууц 349, нийт 2556 амьдрах орон сууц, Аялал жуулчлалын бааз 25, амьдарч байгаа хүн амын тоо 43050 болж суурьшлын бүс бий болсон байна.		

²¹ а) биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой ашиглах талаар үндэсний бодлого, хэтийн чиглэл, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах эсхүл энэхүү Конвенцид туссан, холбогдох Хэлэлцэн тохиролцогч Талуудад хамаатай арга хэмжээнүүдийг илэрхийлж буй одоо баримталж байгаа бодлого, хэтийн чиглэл, төлөвлөгөө, хөтөлбөрөө зохицуулан өөрчлөх, б) биологийн олон янз байдлыг хамгаалах, тогтвортой ашиглах арга хэмжээнүүдийг холбогдох салбар, салбар хоорондын төлөвлөгөө, хөтөлбөр, бодлогод аль болохоор тусгах.

3.2 Монгол Улс нэгдэн орсон Нэгдсэн Үндэстний байгууллагын байгаль орчны хөтөлбөр /UNEP/-аас баталсан Биологийн олон янз байдлын тухай конвенцын шаардлагыг хангах, Богдхан уулыг Дэлхийн шим мандлын сүлжээнд бүртгүүлсэн 41,650 га талбайн хэмжээг бууруулахгүйгээр хамгаалах нь зүйтэй байна.

3.3 БОАЖЯ нь ТХГНтХ-ийн 27 дугаар зүйлийн 27.9²², 33 дугаар зүйлийн 33.1²³, 34 дүгээр зүйлийн 34.1²⁴, 36 дугаар зүйлийн 36.1²⁵, 40 дүгээр зүйлийн 40.1²⁶ дэх хэсэгт заасны дагуу ТХГН-т иргэн, хуулийн этгээдэд газар ашиглуулах эрх олгох, хугацааг сунгах, хүчингүй болгох ерөнхий зохицуулалттай.

3.4 Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.8-д "...иргэн, хуулийн этгээдэд газар ашиглуулах асуудлыг дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэхээр заасан.

3.5 Гэтэл ТХГН-ийн зөвшөөрөгдсөн бүсэд иргэн, хуулийн этгээдэд газар ашиглуулах зөвшөөрөл олгоход тавих шалгуур, шалгаруулалтын талаар тодорхой зохицуулалтгүйгээс тус бүсэд газар ашиглуулах үйл ажиллагаанд Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан *"газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах"* зарчим хэрэгжихгүй байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд зөвшөөрөл олгосон зарим заалтыг тодорхой ойлгомжтой байдлаар тусгаагүй байна

3.6 ТХГНтХ-ийн 11 дүгээр зүйлд Дархан цаазат газрын **"хязгаарлалтын бүсийн дэглэмд байгаль орчинд нь сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр зохих зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж болно"**, 11.7-д **"аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах"** гэж тус тус заасны дагуу иргэн, хуулийн этгээдэд газар ашиглах эрхийн гэрчилгээг олгох зохицуулалттай.

3.7 Мөн хуулийн 13 дугаар зүйл **"Байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс"** болон 17 дугаар зүйлийн 17.3-д **"аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн ашиглах барилга байгууламжийг батлагдсан зураг, төсөл, зөвшөөрлийн дагуу барих"** гэж тус тус заасан байна.

3.8 Дээрх хязгаарлалтын бүсүүдэд орон байр, барилга байгууламж **барих зөвшөөрлийг ямар байгууллага, албан тушаалтан олгох талаар нарийвчлан заагаагүй байна.**

3.9 Харин хуулийн 38 дугаар зүйл **"Газар ашиглагчийн эрх үүрэг"**-ийг тодорхойлсон зүйлийн 38.3-т **"хууль буюу гэрээнд заасан үйл ажиллагаа явуулахтай холбогдуулан ашиглаж байгаа газрынхаа төлөв байдал, ашиглалтын зориулалтыг өөрчлөхөд хүрвэл холбогдох зураг төслөө төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж зөвшөөрөл авах"** гэж заасан байна.

3.10 Хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 **"судалгаа, шинжилгээ хийх зөвшөөрөл авсан байгууллагатай гэрээ байгуулах, тухайн газар нутгийн хамгаалалтын горимын хүрээнд явуулж болох үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, хяналт тавих"** гэж зааснаар Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа нь зарим зөвшөөрлийг олгохоор заасан байна.

²² тусгай хамгаалалттай газар нутгийн зөвшөөрөгдсөн бүсэд тодорхой зориулалтаар ашиглаж болох газар, түүний хэмжээ, ашиглах журам, уг газарт байлгаж болох малын төрөл, тоог тогтоох;

²³ "Дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тодорхой зориулалт, хугацаа, болзолтойгоор байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр гэрээний үндсэн дээр ашиглуулж болно."

²⁴ Энэ хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан газар ашиглах тухай гэрээний хугацаа 5 жилээс илүүгүй байх бөгөөд уг гэрээг нэг удаад сунгах хугацаа 5 жилээс илүүгүй байна.

²⁵ Төрийн захиргааны төв байгууллага нь дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэрийг хамгаалалтын захиргаа болон сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн гаргана.

²⁶ Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах эрх дараах тохиолдолд дуусгавар болно.

Хүснэгт 11 ТХГНтХ-ийн орон байр, барилга байгууламж барихтай холбоотой заалт

Орон байр, барилга байгууламж барихтай холбоотой заалтууд		Орон байр, барилга байгууламж барихыг хориглосон зохицуулалтууд
I	Дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд зөвшөөрөлтэйгөөр явуулж болох үйл ажиллагаа:	Дархан цаазат газарт хориглох үйл ажиллагаа:
	11.1.7/ аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн түр буудаллах, отоглох, ажиглалт, судалгаа шинжилгээ хийх зориулалтаар зохих журмын дагуу барьсан орон байрыг ашиглах;	12.1.5/энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 7-д зааснаас өөр барилга байгууламж барих; 12.1.9/ өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн барилга байгууламж барих, зохих зөвшөөрөлгүйгээр мал бэлчээрлүүлэх;
II	Байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд зөвшөөрөлтэйгөөр явуулж болох үйл ажиллагаа:	Байгалийн цогцолборт газарт хориглох үйл ажиллагаа:
	17.1.3/ аялагч, зөвшөөрөл бүхий бусад хүн ашиглах барилга байгууламжийг батлагдсан зураг, төсөл, зөвшөөрлийн дагуу барих;	18.1.3/ батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсвийг зөрчиж, суурингийн нутаг дэвсгэрийг тэлэх, барилга, байгууламж барих.
III	Байгалийн нөөц газрын дэглэм	
	Зөвшөөрсөн: 21.1/ Байгалийн нөөц газарт хамгаалалтад авсан байгалийн хэв шинж, тодорхой баялгийн төрх байдал, ургамал, амьтны аймгийн байршил, өсөлт, үржилтэд сөрөг нөлөөгүйгээр уламжлалт аж ахуй эрхлэж болно. Хориглосон: 21.2/ Байгалийн нөөц газарт түүний байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн зориулалтаар газар ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, ан амьтан агнах, барих, мод, зэгс, шагшуурга бэлтгэх зэргээр байгалийн унаган төрхийг өөрчлөх, мал аж ахуй эрхлэгч малчин өрхөд өвөлжөө, хаваржааны газар олгох, голын усыг бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно.	
IV	Дурсгалт газрын дэглэм	
	24.2/ Дурсгалт газар дахь байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлээс 0.1-3.0 км-ийн орчимд сүр бараа, үзэмжийг нь дарах барилга байгууламж барих, газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийг хөндөх, эвдэх, буулгах, тэдгээрт хохирол учруулахуйц бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.	
V	Хамгаалалтын захиргааны үйл ажиллагаа	
	30.1.7/ зөвшөөрөгдсөн бүс дэх сууринг тохижуулах, барилга байгууламж барих ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байгаад хяналт тавих;	

/Эх сурвалж: БОАЖЯ-ны хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний шинжилгээний тайлан/

Тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн улсын бүртгэлд орсон өөрчлөлтийг БОАЖЯ-нд мэдэгдэх эрх зүйн зохицуулалт бий болгох шаардлагатай байна

3.11 ТХГНтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.2-д “Тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын хуулийн этгээд олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахыг хориглоно” гэж заасан байна.

3.12 Аудитын явцад мэдээллийн хэрэгсэл болон иргэдээс ирсэн гомдолд “гадаадын иргэн тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байна” гэсний дагуу шалгахад дотоодын хуулийн этгээд газар ашиглах хүсэлт гаргах үедээ хуульд заасны дагуу баримт материал бүрдүүлэн газар ашиглах эрхийн гэрчилгээ авсны дараа компанийн дүрмийн санд өөрчлөлт оруулан гадаадын иргэнд 50-иас дээш хувийн хувьцаагаа шилжүүлсэн байна.

3.13 Энэ тохиолдолд ТХГНтХ-ийн 33.2²⁷ дахь заалт зөрчиж байгаа бөгөөд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлд 22.1-д “Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.”, 22.3-д “Хуулийн этгээдийн эрх шилжүүлэх өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ.” гэж заасан байна.

3.14 Мөн хуулийн 22.4-д “Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх өргөдлийг энэ хуулийн 12.4, 14.1, 15.1-д заасны дагуу гаргах бөгөөд улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 21.6-д заасан хугацаанд бүртгэх эсэхийг шийдвэрлэж, хариу мэдэгдэнэ” гэж заасан байна.


²⁷ Тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын хуулийн этгээд олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахыг хориглоно

3.15 Тусгай хамгаалалтын захиргаа болон төрийн захиргааны төв байгууллагад тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж буй хуулийн этгээдийн хувь эзэмшигчдийн талаар улсын бүртгэлийн байгууллагаас лавлагаа авч, гадаадын иргэн хувь эзэмшиж байгаа тохиолдолд хуульд заасны дагуу арга хэмжээг авах шаардлагатай байна.

Нийслэлийн ИТХ Дархан цаазат газарт хориглох үйл ажиллагааг зөрчсөн тогтоол гаргасан байна

3.16 БОАЖЯ нь ТХГНТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.8-д заасны дагуу суурин газрын ерөнхий төлөвлөгөө, шинээр байгуулах аялал, жуулчлалын бааз, амралт, сувиллын байршил, төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран хянан батлаагүй байна. ТХГНТХ-д зааснаар газар ашиглуулах процессын зураглалыг үзүүлбэл дараах байдалтай байна.

Зураглал 2 ТХГН-т газар ашиглуулах эрхийг авах үйл явц



3.17 Иргэн, хуулийн этгээдийн газар ашиглах хүсэлтийн дагуу Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа нь солбицол бүхий газрын байршлын давхцалыг шалгаж, саналаа ТХГН-ийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлж байна. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар харуулбал:

Хүснэгт 12 БОАЖЯ-аас тусгай хамгаалалттай газар ашиглах эрх олгосон мэдээлэл

Хэлбэр	Тусгай хамгаалалттай газар /га/							
	Дархан цаазат газар		Байгалийн цогцолборт газар		Байгалийн нөөц газар		Дурсгалт газар	
	Тоо	Хэмжээ	Тоо	Хэмжээ	Тоо	Хэмжээ	Тоо	Хэмжээ
Ашиглах	1775	5,848.3	1870	131,285.3	6	10.1	8	22.5
Нийт	1775	5,848.3	1870	131,285.3	6	10.1	8	22.5

/Эх сурвалж: ГХГЗЗГ-аас/

3.18 ТХГНТХ-ийн 35 дугаар зүйлийн 1³⁰, 36 дугаар зүйлийн 36.1-д “Төрийн захиргааны төв байгууллага нь дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэрийг хамгаалалтын захиргаа болон сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн гаргана.” гэж заасан боловч өмчлүүлэх, эзэмшүүлэх эрхээр ТХГН-т аймаг, нийслэлийн, сум, дүүргийн засаг дарга нар газар олгосон байна. Үүнд:

³⁰ Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасан журмыг баримтлан газар ашиглах тухай хүсэлтээ хамгаалалтын захиргаа буюу хамгаалалтын захиргаа байгуулаагүй тусгай хамгаалалттай газар нутагт сум, дүүргийн Засаг даргад гаргана.

Хүснэгт 13 Улсын хэмжээнд нийт тусгай хамгаалалттай газар олгосон мэдээлэл

Хэлбэр	Тусгай хамгаалалттай газар							
	Дархан цаазат газар		Байгалийн цогцолборт газар		Байгалийн нөөц газар		Дурсгалт газар	
	Тоо	Хэмжээ	Тоо	Хэмжээ	Тоо	Хэмжээ	Тоо	Хэмжээ
Өмчлөх	127	1.5	1582	361.0	1	0.15	50	3.1
Эзэмших	1407	2,364.5	3659	16,109.9	4692	1,243.6	47	420.4
Ашиглах	1775	5,848.3	1870	131,285.3	6	10.1	8	22.5
Нийт	3208	8,214.3	7111	147,756.2	4699	1,253.8	105	446.0

/Эх сурвалж: ГЗБГЗЗГ-ын мэдээллийн сангийн 2022 оны байдлаар/

3.19 БОАЖЯ, ТЕГ, ГЗБГЗЗГ, нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын алба зэрэг байгууллагуудын газар ашиглаж буй иргэн, хуулийн этгээдийн судалгаа, мэдээлэл зөрүүтэй байгаа нь Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1³¹, 9 дүгээр зүйлийн 9.1.1³², 23 дугаар зүйлийн 23.2.14³³, 23.2.22³⁴, 26 дугаар зүйлийн 26.2³⁵-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хоорондын ажлын уялдаагүй, хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж ирсэнтэй холбоотой байна.

3.20 ТЕГ-ын 2022 оны 02/2670 дугаар албан бичгийн хавсралтаар Богдхан уулын ДЦГ-т 2020-2022 оны газрын төлбөрийн өртэй 1702 иргэн, хуулийн этгээдийн 49,124.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гэсэн мэдээ ирүүлсэн.

3.21 Гэтэл ГЗБГЗЗГ-ын 2023 оны 01/172 дугаар албан бичгээр ирүүлсэн мэдээлэлд Богдхан уулын ДЦГ-т 2,716.6 га газрын 2396 иргэн, хуулийн этгээдийн жагсаалт ирүүлснийг ТЕГ-ын мэдээлэлтэй тулган шалгахад 694 иргэн, хуулийн этгээдийн 8,270.9 сая төгрөгийн газрын төлбөрийн мэдээлэл зөрүүтэй байна.

3.22 Энэ нь БОАЖЯ тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах гэрчилгээ авсан иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг газрын нэгдсэн санд бүрэн оруулдаггүй, ГЗБГЗЗГ нь мэдээллээ ТЕГ-т бүрэн өгөөгүйгээс шалтгаалсан байна.

3.23 Аудитад ГЗБГЗЗГ-аас ирүүлсэн судалгаа, мэдээлэлд үндэслэн ТХГН-т төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан иргэдэд эзэмших, өмчлөх эрх олгосон байдлыг дараах байдлаар харуулав. Үүнд:

Хүснэгт 14 Тусгай хамгаалалттай газарт газар олгосон Засаг дарга нарын шийдвэр /2022 оны байдлаар/

Газрын нэр	Шийдвэр гаргасан байгууллага	Ашиглах эрх		Эзэмших эрх		Өмчлөх эрх	
		Иргэн, хуулийн этгээдийн тоо	Газрын хэмжээ /га/	Иргэн, хуулийн этгээдийн тоо	Газрын хэмжээ /га/	Иргэн, хуулийн этгээдийн тоо	Газрын хэмжээ /га/
Богдхан уулын дархан цаазат газар	БОАЖЯ	1731	2,555.7				
	Нийслэлийн ЗД	9	33.6	72	11.0	124	79.1
	Дүүргийн ЗД	2	0.1	449	37.1		
Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газар	БОАЖЯ	849	1638.8				
	Нийслэлийн ЗД	1	5.1	2	0.42		
	Дүүргийн ЗД/НД/	4	5.9	70	39		
	Сумын ЗД			374	458.9	1169	317.8
Дүн		2596	4239.2	967	546.5	1293	396.9

/Эх сурвалж: ГХГЗЗГ-аас/

³¹ 4.1.1.Монгол Улсын газар нутаг салшгүй бүрэн бүтэн, газрын сан нэгдмэл байх;

³² 9.1.Монгол Улсын хилийн доторх бүх газар нь өмчийн төрөл, хэлбэрээс үл хамааран газрын нэгдмэл сан мөн.

³³ улсын хэмжээнд газрын кадастрын бодлогыг хэрэгжүүлэх, улсын газрын мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх;

³⁴ газрын төлөв байдал, нөөц, чанарын өөрчлөлтийг тодорхойлох, газар эзэмшигч, ашиглагчийн бүртгэлийг эрхлэх зорилго бүхий газрын нэгдмэл сангийн мэдээллийн сан, сүлжээг орчин үеийн техник, технологид тулгуурлан бий болгох.

³⁵ 26.2.Газрын кадастрт энэ хуулийн 9-16 дугаар зүйлд заасан газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрын улсын бүртгэл, газрын тоо бүртгэл, чанар, үнэлгээ, төлбөр, шилжилт хөдөлгөөн, газар хамгаалах талаар авсан арга хэмжээ зэрэг үзүүлэлтийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүрээр тусгасан байна.

3.24 БОАЖЯ нь Дархан цаазат болон Байгалийн цогцолбор газрын тодорхой хэсгийг иргэн, хуулийн этгээдэд гэрээний үндсэн дээр ашиглуулахаар заасан боловч аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нар эрх мэдлээ хэтрүүлэн 967 иргэн, хуулийн этгээдэд эзэмших эрхийн гэрчилгээ, 1293 иргэн, хуулийн этгээдэд өмчлөх эрх олгосон нь ТХГНТХ-д заагаагүй эрх эдэлж хязгаарлалтын бүсийн дэглэмийг зөрчсөн байна.

3.25 ТХГН-т нийслэлийн ИТХ “Нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө” батлах тухай тогтоол гаргаж, иргэдэд гэр бүлийн хэрэгцээнд газар эзэмшүүлэхээр төлөвлөн баталж байна. Тухайлбал;

- 2019 оны газрын ерөнхий төлөвлөгөөнд ХУД-ын нутаг дэвсгэрт гэр бүлийн хэрэгцээнд Арцатын ам 18 иргэнд 0.9 га, Жаргалантын ам 24 иргэнд 1.1 га газар;
- 2020 оны төлөвлөгөөнд Арцатын гудамж 5 айл, 0.25 га, Тайнь, Бурхант, Буянт-Ухаагийн гудамж 35 айл, 2.5 га газар;
- 2021 оны төлөвлөгөөнд Тайнь, Бурхант, Буянт-Ухаагийн гудамж 10 айл, 0.6 га газар;

3.26 Энэ нь ТХГН-ийн хилийн цэсийг өөр өөр байдлаар зурагласнаас тусгай хамгаалалттай газар нутагт нийслэл, дүүргээс газар давхардуулан олгож, маргаан үүсгэх нөхцөлийг бий болгож байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглагч иргэн, хуулийн этгээдтэй газар ашиглах тухай гэрээг байгуулж, дүгнэх ажил бүрэн хийгээгүй байна

3.27 ТХГНТХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1-д "Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар ашиглах тухай гэрээг өөрөө буюу хамгаалалтын захиргаатай хамтран байгуулна." гэж заасан.

3.28 Байгаль орчны сайдын 2001 оны 218 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар Улсын тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэрт газар ашиглах тухай гэрээний маягтыг баталсан бөгөөд газар ашиглах тухай гэрээг 5 жилийн хугацаатай байгуулж, журмын дагуу гэрээг жил бүр дүгнэж биелэлтийг тооцохгүй байна. Үүнд:

Хүснэгт 15 Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах гэрээний хэрэгжилт

№	Нэр	Газар ашиглах гэрээ				
		Нийт	гэрээгүй	гэрээтэй	дүгнэсэн	дүгнээгүй
1	Богдхан уулын ДЦГ	1138	434	704	395	309
2	Горхи-тэрэлж БЦГ	199	80	119	38	81
3	Хөвсгөлийн БЦГ	154	87	67	21	46
Дүн		1491	601	890	454	436

3.29 ТХГН-т 2021-2022 онд үйл ажиллагаа явуулсан 601 иргэн, хуулийн этгээдтэй газар ашиглах гэрээг байгуулаагүй, 436 иргэн, хуулийн этгээдтэй гэрээний биелэлтийг дүгнээгүй байна.

Тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээдийн газар ашигласны төлбөрийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна

3.30 ТХГН-т газар ашиглах эрхийн зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээдийн нэгж талбарын мэдээллийг газрын кадастрын дундын мэдээллийн санд бүртгэх эрхийг хамгаалалтын захиргааны газар ашиглалт хариуцсан ажилтанд олгосон байна. Газрын мэдээллийн санд нэгж талбарын мэдээллийг бүрэн оруулснаар газрын төлбөрийг хуульд заасан хувь хэмжээгээр ногдуулах эрх үүсдэг байна.

3.31 ТХГН-т газар ашигласны төлбөр төлөөгүй 2208 иргэн, хуулийн этгээдийн 41,978.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнд:

Хүснэгт: 16 Газрын төлбөр төвлөрүүлээгүй үлдэгдэл /2020-2022 оны байдлаар/

№	Хамаарах дүүрэг	Хамаарах УТХГН	Иргэн хуулийн этгээдийн тоо	нэгж талбарын тоо /га/	Газрын төлбөрийн үлдэгдэл
1	Баянзүрх дүүрэг	Богдхан уулын ДЦГ	186	976.6	19,476.5
2	Хан Уул дүүрэг	Богдхан уулын ДЦГ	1269	1454.9	21,377.0
3	Налайх дүүрэг	Горхи Тэрэлжийн БЦГ	715	1488.0	1,089.9
4	Хөвсгөл аймаг	Хамгаалалтын захиргаа	38	287.7	35.3
Дүн			2208	4207.2	41,978.7

Хүснэгт 17 Газрын нэгдсэн мэдээллийн санд бүртгэлтэй боловч гэрээний хугацаа дууссанаас нэхэмжлэл үүсээгүй иргэн, хуулийн этгээдийн тоо /2020-2022 оны байдлаар/

№	Хамаарах дүүрэг	Хамаарах УТХГН	Иргэн хуулийн этгээдийн тоо	нэгж талбарын тоо /га/	ногдох газрын төлбөр /сая төг/
1	Баянзүрх дүүрэг	Богдхан уулын ДЦГ	3	7.13	198.2
2	Хан-Уул дүүрэг	Богдхан уулын ДЦГ	30	74.34	852.4
3	Налайх дүүрэг	Горхи-Тэрэлжийн БЦГ	34	72.3	68.9
4	Хөвсгөл аймаг	Хөвсгөлийн БЦГ	19	80.0	52.9
Дүн			86	233.8	1,172.4

3.32 ТХГН-т газар ашиглах зөвшөөрлийн хугацааг сунгуулаагүйгээс нэхэмжлэл үүсээгүй, төлбөр авах боломжгүй болсон учир дээрх 86 иргэн, аж ахуйн нэгжээс 2020-2022 онд 1,172.4 сая төгрөгийн газрын төлбөрийг ногдуулах боломжгүй болсон байна. Энэ нь газар ашиглагч иргэд цаг тухайд нь газрын зөвшөөрлөө сунгуулах үүргээ биелүүлээгүй, хамгаалалтын захиргаанаас шаардлага тавиагүй, заавал цахим программаар нэхэмжлэл үүсгэж байж төлбөр авах эрх үүсдэгтэй холбоотой байна.

3.33 ТХГН-т газар ашиглуулахаар шийдвэрлэсэн иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг ГЗБГЗЗГ-ын цахим системд орсон газрын төлбөрийн мэдээлэлтэй тулгаж үзэхэд Горхи-Тэрэлжийн БЦГ-ын нэр бүхий 152 иргэн, хуулийн этгээдийн 237.1 га газар, Хөвсгөлийн БЦГ-ын 56 нэгж талбарын мэдээллийг оруулаагүйгээс Газрын төлбөрийн тухай хуулийн 4³⁶-д газрын төлбөрийн нэхэмжлэл үүсгэн, ногдуулалт хийгээгүй байна.

3.34 Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5³⁷, 40.1.6³⁸ заасны дагуу ТХГН-ийн хамгаалалтын захиргаадаас гаргасан газар ашиглах эрхийг дуусгавар болгох, цуцлах саналд Горхи-Тэрэлжийн БЦГ-т 51, Богдхан уул ДЦГ-т 286, Хөвсгөл нуурын БЦГ-т 35 иргэн, аж ахуйн нэгж байна.

Газар ашиглах эрхийн гэрчилгээнд заасан зориулалтын дагуу газрыг ашиглахгүй байна

3.35 Богдхан уулын ДЦГ-т БОАЖЯ, нийслэл, дүүргийн Засаг дарга нар 2286 иргэн, хуулийн этгээдэд газар олгосноос 2022 оны байдлаар зориулалтын дагуу буюу аялал, жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нь 42 хуулийн этгээд байна.

3.36 ТХГНтХ-ийн 1239 дугаар зүйлд зассан хориглосон, зориулалтын бус үйл ажиллагааг дараах хуулийн этгээдүүд явуулж байна. Тухайлбал:

³⁶ “Газар эзэмшүүлэх, ашиглуулах эрх бүхий этгээдийн шийдвэрийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа, Газрын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан газрын нэгдмэл сангийн үндсэн ангилалд хамаарах болон тусгай хэрэгцээний газарт төлбөр ногдуулна.” 9 дүгээр зүйлийн 2 дэх хэсэгт “Газрын төлбөрийн асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан газрын жилийн төлбөрийг ногдуулж тухайн оны 02 дугаар сарын 10-ны дотор татварын албанд хүргүүлнэ.”

³⁷ эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй;

³⁸ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй.

³⁹ Дархан цаазат газарт энэ хуулийн 10,11 дүгээр зүйлд зааснаас өөр зориулалтаар дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

Хүснэгт 18 Богдхан уул ДЦГ-т байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихтэй үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн жагсаалт

№	Компани	Газрын бүртгэлийн дугаар	Хаяг	Үйл ажиллагааны чиглэл	Одоогийн үйл ажиллагаа	Талбайн хэмжээ/ га/
1	Тэхэ ХХК	1781000769	Хүүшийн ам	Эко авто аялал	ШТС	1.6 га
2	Шунхлай трейдинг ХХК	1781101858	Нүхтийн ам	Аялал, жуулчлалын бааз	ШТС	0.08 га
3	Тэс петролиум ХХК	Бүртгэл байхгүй	Нүхтийн ам	Аялал, жуулчлалын бааз	ШТС	-
4	Паркнайн ХХК	1781111061	Нүхтийн ам	Аялал, жуулчлалын бааз	Уурын зуухтай орон сууц	2.0 га
5	Вүүден ХХК	1781000421	Зайсангийн ам	Аялал, жуулчлалын бааз	Машин угаалга	1.1 га
6	Силкю ундарга ХХК	1781001142	Зайсангийн ам	Аялал, жуулчлалын бааз	Машин угаалга	0.17 га
7	Иргэн Д.Батмөнх	1781000990	Зайсангийн ам	Аялал, жуулчлалын бааз	Гийн-гоо машин угаалгын газар	0.05 га
8	Иргэн Ё.Батсүрэн	1781001120	Зайсангийн ам	Аялал, жуулчлалын бааз	Машин угаалга	0.18 га

3.37 Богдхан уулын ДЦГ-ын хязгаарлалтын бүс болох Нүхтийн аманд Тэс петролиум ХХК шатахуун түгээх станц ажиллуулж байгаа нь газрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэлгүй, газар ашиглах зөвшөөрөлгүй, газрын төлбөр төлөхгүйгээр үйл ажиллагаа явуулж байна.

ТХГН-т газар ашиглах эрхийн гэрчилгээ авсан зарим иргэн, хуулийн этгээд улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй байна

3.38 ТХГН-т үйл ажиллагаа явуулахаар газар ашиглах зөвшөөрөл авсан иргэн, хуулийн этгээдээс улсын төсөвт төвлөрүүлэх тэмдэгтийн хураамжийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.11⁴⁰ дэх заалтын дагуу бүрэн төвлөрүүлээгүй байна. Үүнд:

Хүснэгт 19 Улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй иргэн, хуулийн этгээдийн жагсаалт /2022.07.01-ний байдлаар/

№	Иргэн, хуулийн этгээд	Тусгай хамгаалалттай газар	Харьяалал	дүн /сая.төг/
1	Голдэн сэкл холдинг ХХК	Богдхан уулын ДЦГ	ХУД	20.0
2	Эн ди ти инженеринг ХХК	Богдхан уулын ДЦГ	ХУД	45.0
3	Лувсан данзан равжаа академи ТББ	Богдхан уулын ДЦГ	ХУД	117.5
4	Лувсан данзан равжаа академи ТББ	Богдхан уулын ДЦГ	ХУД	131.5
5	Элдора трейд ХХК	Богдхан уулын ДЦГ	ХУД	13.3
6	Хонгорцэен ХХК	Богдхан уулын ДЦГ	Төв аймаг	5.1
7	Агро ферм холдинг ХХК	Богдхан уулын ДЦГ	ХУД	99.3
8	Уран консалтинг ХХК	Богдхан уулын ДЦГ	ХУД	100.1
9	Бат билэг гурван эрдэнэ ХХК	Богдхан уулын ДЦГ	НД	7.5
10	Палома ХХК	Богдхан уулын ДЦГ	Төв аймаг	10.0
11	Жаргалантын ам травел партнерс ХХК	Богдхан уулын ДЦГ	ХУД	3.5

⁴⁰ дархан цаазат газрын болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц газар, дурсгалт газраас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглуулах тухай шийдвэрийг хамгаалалтын захиргаа болон сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шийдвэр гаргаж зөвшөөрөл олгоход нийслэлд м² тутамд 500 төгрөг, аймагт м² тутамд 100 төгрөг;

12	Сорголжин тур ХХК	Богдхан уулын ДЦГ	Төв аймаг	3.0
13	Гэрэгэ поло ХХК	Богдхан уулын ДЦГ	ХУД	5.0
14	Экодэйвэри сервис ХХК	Горхи-Тэрэлж БЦГ	НД	2.0
15	Иргэн А.Хатанбаатар	Богдхан уулын ДЦГ	ХУД	0.4
16	Транкюлити тур ХХК	Горхи-Тэрэлж БЦГ	НД	8.5
17	Прешиүс фэйт ХХК	Горхи-Тэрэлж БЦГ	НД	20.0
18	Ньюгрэйд мэн ХХК	Богдхан уулын ДЦГ	ХУД	4.6
19	Иргэн Д.Нямдагва	Богдхан уулын ДЦГ	БЗД	36.9
20	Бат боргоцой ХХК	Богдхан уулын ДЦГ	БЗД	50.0
21	Улаан шовх ХХК	Богдхан уулын ДЦГ	ХУД	5.1
22	Блуеком ХХК	Горхи-Тэрэлж БЦГ	НД	10.0
23	Ундрал буд ХХК	Горхи-Тэрэлж БЦГ	НД	42.2
24	Хүмүүнлэг эмэгтэйчүүдийн холбоо НҮТББ	Богдхан уулын ДЦГ	ХУД	9.5
25	Отгоодор ХХК	Орхоны хөндийн БЦГ	Өвөрхангай	13.0
26	Дулаан сэтгэл нийгэмлэг ТББ	Богдхан уулын ДЦГ	ХУД	31.3
27	Бату констракшн ХХК	Богдхан уулын ДЦГ	ХУД	2.5
28	Иргэн С.Будсүх	Горхи-Тэрэлж БЦГ	НД	10.0
НИЙТ				807.0

3.39 БОАЖЯ нь газар ашиглах эрхийн гэрчилгээ олгосон дээрх иргэн, хуулийн этгээдээс Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийг хэрэгжүүлж улсын тэмдэгтийн хураамжийг төлүүлж барагдуулах шаардлагатай байна.

ТХГН-т байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийсэн ажлууд тодорхой бус, түүнийг үнэлж, дүгнэх ажлыг бүрэн хийгээгүй байна

3.40 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар Тусгай хамгаалалттай газар нутагт үйл ажиллагаа явуулж буй төслийн **Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ**⁴² Улсын ТХГН-ийн хилийн цэсэд Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн хамгаалалтад авсан газар нутагт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хариуцан гүйцэтгэхээр заажээ.

3.41 Мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1⁴³, 9.2⁴⁴, 9.8-д “төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална” гэж тус тус заасан байна.

3.42 ТХГН-т аялал, жуулчлалын баазын 80 гаруй хувь байрладаг бөгөөд 2021 оны байдлаар аялал жуулчлалын зориулалтаар үйл ажиллагаа явуулж буй 304 иргэн, хуулийн этгээдийн 80.8 хувь нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүйгээр үйл ажиллагаа явуулсан байна.

3.43 БОНБУТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.2-т “байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нутгийн оршин суугчид, орон нутгийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөгч талууд холбогдох төрийн захиргааны төв байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж, тайлагнах”, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 4.12-т “Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг аймаг, нийслэлийн томилсон ажлын хэсэг газар дээр нь

⁴² “байгаль орчны нөлөөллийн үнэлгээ гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг хэлнэ.

⁴³ Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн байгууллага боловсруулна.

⁴⁴ Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгоно.

хянаж үнэлсэн нэгдсэн дүн 90 онооноос дээш гүйцэтгэлтэй байвал төсөл хэрэгжүүлэгчээс боловсруулж ирүүлсэн дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан батлах нэг нөхцөл болно” гэж заасан байна.

3.44 Мөн БОНБУТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.9, 9.10⁴⁵-т зааснаас бусад төрлийн төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг тус сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана,” гэсэн заасны дагуу Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлсэн хөрөнгө одоогоор байхгүй байна.

Олон Улсын Байгаль хамгаалах холбооны сайн туршлага

3.45 Олон Улсын Байгаль Хамгаалах Холбоо, Дэлхийн байгаль хамгаалах сан, Мониторингийн төвөөс хамтран боловсруулсан тусгай хамгаалалттай газар нутгийн дараах 6 ангиллыг олон улсын түвшинд мөрдөж байна.

Хүснэгт 20 Олон Улсын байгаль хамгаалах холбоо болон МУ-ын ТХГН-ийн ангилал, тодорхойлолт

Дэлхийн байгаль хамгаалах холбоо IUCN-ийн ангилал (Нэгдүгээрх нь а болон б гэсэн дэд хэсэгтэй)			МУ-ын Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал	
№	Ангилал	Тодорхойлолт	Ангилал	Тодорхойлолт
Ia	Дархан цаазат газар	Хуурай болон далайн бүсэд орших онцлог экосистем болон геологи/геоморфологи, биологийн олон янз байдал бүхий, аливаа ашиглалт нөлөөлөл нь хязгаарлагдсан, тусгай хамгаалалттай газар нутаг.	Дархан цаазат газар	Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах унаган төрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дархан цаазат газар
Ib	Зэрлэг онгон газар	Биологийн олон янз байдал, түүний амьдрах орчин нь хүний үйл ажиллагааны нөлөөнд автаагүй, байгалийн унаган төрхийг нь хадгалах зорилготой бүс нутаг.		
II	Байгалийн цогцолборт газар	Өөрийн гэсэн амьтан, ургамлын төрөл зүйл, экосистемийн онцлогтой, байгаль, соёлын өвийг хамгаалах хэмжээнд оюун санаа, шинжлэх ухаан, боловсролыг дэмжсэн үйл ажиллагаа, амралт зугаалга, аялал хийх боломжтой, Экосистемийн баялаг процессыг хадгалж үлдсэн хөндөгдөөгүй, эсвэл бага хэмжээгээр хөндөгдсөн томоохон газар нутаг.	Байгалийн цогцолборт газар	Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн цогцолборт газар
III	Байгалийн дурсгалт газар	Хуурай газрын тогтоц, тэнгисийн эрэг, далайн цүнхээл, агуй, балар эртний амьд ой гэх мэт. Геологийн тогтцуудыг хадгалах зорилгоор хамгаалсан газар нутаг.	Дурсгалт газар	Байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын үл мөрийг уламжлагдан хадгалагдсан байгалийн байдлаар нь өвлөн үлдээх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дурсгалт газар
IV	Амьдрах орчин, биологийн олон янз байдлыг хамгаалах менежментийн бүс нутаг	Биологийн олон янз байдлын тодорхой зүйлийн амьтан ургамал, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах зорилгоор хамгаалалтад авсан газар нутаг.	Байгалийн нөөц газар	Байгалийн тодорхой хэв шинж, аль нэгэн нөөц, баялгийг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн нөөц газар
V	Хуурай газар болон далай тэнгисийг хамгаалсан ТХГН	Хуурай газар, далай тэнгис, эрэг орчмын нутгийг хамрах бөгөөд хүн байгалийн харилцан шүтэлцээнээс экологи, соёл, гоо зүйн чухал ач холбогдол бүрэлдсэн газар.		
VI	Байгалийн нөөцийг тогтвортой ашиглах ТХГН	Экосистемийг уламжлалт ахуй соёл, байгалийн нөөц ашиглалтын уламжлалт менежменттэй нь цуг хадгалж, хамгаалдаг газар нутаг.		

/Эх сурвалж: 2022 он www.iucn.org/

⁴⁵ Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч

3.46 Олон улсад хот орчмын тусгай хамгаалалттай газрын бүсчлэлийг онцгой болон хамгаалалтын гэж ангилсан тохиолдол цөөн байна. Харин онцгой, хамгаалалтын, хязгаарлалтын гэсэн гурван шатлалтай ТХГН байхгүй байна.

3.47 Олон улсад ТХГН-ийн засаглалын шинж удирдлага, зохион байгуулалт, менежментийн хэлбэрүүд, эрх мэдэл хэн удирдахаас хамаарч ялгаатай байна. Үүнд:

Хүснэгт 21 Дэлхийн байгаль хамгаалах холбооны ТХГН-ийн засаглалын төрөл

Засаглалын төрөл		Төрөлд хамаарах ангилал
1	Төрийн төвлөрсөн засаглал:	-Холбооны эсвэл улсын яам/агентлаг; -Орон нутгийн шинжтэй яам эсвэл агентлаг (бүсийн, аймгийн, хотын түвшний удирдлага гэх мэт); -Засгийн газрын эрхийг төлөөлөн хэрэгжүүлэгч (ТББ- д гэх мэт)
2	Эрх мэдлээ хамтран хэрэгжүүлдэг засаглал:	-Хил дамнасан засаглал (2 ба түүнээс дээш улс орнууд хоорондоо албан болон албан бус харилцаагаар зохицуулдаг); -Хамтын ажиллагаа дээр суурилсан засаглал (олон талын этгээд, байгууллагууд төрөл бүрийн байдлаар хамтран ажилладаг хэлбэр); -Хамтарсан засаглал (олон талын бүрэлдэхүүн, эсвэл олон гишүүнтэй засаглал)
3	Хувийн засаглал:	-Газрын эзэн хувийн газраа ТХГН-т хамруулж, хамгаалалтын үйл ажиллагааг нь өөрөө удирддаг; -Ашгийн төлөө бус байгууллагууд (ТББ, их, дээд сургуулиуд гэх мэт), эсвэл -Ашгийн төлөө байгууллагууд (газар эзэмшдэг корпорацууд гэх мэт).
4	Уугуул болон нутгийн иргэдийн засаглал:	-Уугуул оршин суугчдын хамгаалсан, өөрсдөө удирддаг газар нутаг; -Нутгийн иргэдэд суурилсан хамгаалалттай газар нутгууд гэж тус тус тодорхойлсон байна.

3.48 Олон улсад ТХГН-ийн нөлөөллийн бүсэд барилгажилт, суурьшлын асуудлыг байгаль орчинд ээлтэй байдлаар шийдвэрлэж, төр хувийн хэвшлийн хамтын удирдлагын тогтолцоо түгээмэл бөгөөд төрийн бус менежментийн удирдлага зонхилох хандлагатай байна.

3.49 Монгол Улсад ТХГН-ийг төр, хувийн хэвшлийн түншлэл болон нутгийн иргэдэд суурилсан зохион байгуулалтын менежментийг хөгжүүлэн хэрэгжүүлэх боломж байна.

3.50 ТХГН-т нэвтрэх хураамжийн төлбөрийг бусад орны үнэ тарифтай харьцуулж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт: 22 Гадаад орны ТХГН-ийн нэвтрэх хураамжийн үнийг харьцуулсан байдал

№	Улс	Тусгай хамгаалалттай газар	Нэвтрэх хураамж (том хүн)
1	Америкийн Нэгдсэн Улс	Эзверглэйдэс Байгалийн Цогцолборт Газар	• Машинтай зорчигч: \$30 ам.доллар (7 хоног хүчинтэй) • Мотоциклтэй зорчигч: \$25 ам.доллар (7 хоног хүчинтэй) • Явган/дугуйтай зорчигч: \$15 ам.доллар (7 хоног хүчинтэй)
2	Зимбабве	Виктория Хүрхрээ, Дэлхийн байгалийн өв	• Гадаадын иргэд: \$30 ам. доллар • Бүсийн (SADC) иргэд: \$20 ам.доллар • Нутгийн оршин суугч: \$7 ам. доллар
3	Өмнөд Африк	Кругер Байгалийн Цогцолборт Газар	• Гадаадын иргэд: өдрийн ЗАР460 (\$29 ам. доллар) • Бүсийн (SADC) иргэд: өдрийн ЗАР230 (\$18.5 ам.доллар) • Дотоодын иргэд/оршин суугчид: өдрийн ЗАР115 (\$8.8 ам.доллар)
4	Индонез	Комодо Байгалийн Цогцолборт Газар	• Гадаадын иргэд: өдрийн IDR 150,000 (Даваа–Бямба) (\$11 ам.доллар) • Гадаадын иргэд: өдрийн IDR 225,000 (Ням болон бүх нийтийн амралтын өдөр) (\$16 ам.доллар)
5	Эквадор	Галапагос Байгалийн Цогцолборт Газар	• Нас болон үндэстнээс хамаарч • Гадаадын иргэд: ихэвчлэн \$100 ам.доллар • Дотоодын иргэд: \$6 ам.доллар
6	Монгол Улс	Дархан цаазат болон БЦГ нутаг	• Гадаадын иргэд: 1000 төгрөг (0.3 ам.доллар) • Дотоодын иргэд: 300 төгрөг (0.08 ам.доллар)

3.51 Гадаад улс орны Тусгай хамгаалалтын газар нутагт нэвтрэх хураамжийг хүснэгтээс харахад хураамжийг инфляцын түвшнээр индексжүүлэхийн зэрэгцээ гадаад, дотоодын

иргэдийн төлбөр төлөх сонирхлыг харгалзан манай улс нэвтрэх хураамж, төлбөрийг өөрчлөх шаардлагатай байна.

ДӨРӨВ. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖ, ТӨЛБӨРИЙН АКТ, АЛБАН ШААРДЛАГЫН БИЕЛЭЛТ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА

4.1 Үндэсний аудитын газар 2019 онд “Иргэн, хуулийн этгээдэд газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр, үйл ажиллагаа нь Газрын тухай хуульд нийцсэн эсэх”-д хийсэн нийцлийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 23 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Д.д	Зөрчлийн төрөл	Дугаар	Хариуцагч	Зөрчлийн тоо	Мөнгөн дүн, сая төгрөг						Биелэлт, хувь	
					Эхний үлдэгдэл		Барагдуулсан		Эцсийн үлдэгдэл			
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Төлбөрийн акт	1/132	БОАЖЯ	1	408	5,177.6	74	689.2	334	4,488.4	13.3	
2	Албан шаардлага	1/358	БОАЖЯ	11	1	-	1	-	1	-	100	
					1	-	1	-	1	-	100	
					1	-	-	-	1	-	50	
					1	-	-	-	1	-	70	
					430	4,151.3	83	1.9	347	4,149.4	0.04	
					1	-	1	-	-	-	70	
					1	-	-	-	1	-	0	
					1	-	-	-	1	-	70	
					1	-	1	-	-	-	100	
					1	-	1	-	-	-	100	
					1	-		-	1	-	70	
3		1/359	ГТБЦГХЗ	4	220	2.2	-	-	220	2.2	30	
					-	-	-	-	-	-	50	
					89	110.9	-	-	89	110.9	50	
					51	208.3	-	-	51	208.3	50	
4		1/360	БУДЦГХЗ	3	151	3.4	-	-	151	3.4	50	
					151	112.8	-	-	151	112.8	50	
					1194	-	1164	-	30	-	90	
5			1/361	ХУДИТХ	1	1	-	1	-	-	-	100
6		1/362	ХУД	2	79	522.1	57	679.8	22	67.0	90	
	1049				-	-	-	1049	-	50		
7	1/363	БЗД	3	145	-	100	-	45	-	90		
				5	110.1	2	32.6	3	77.6	90		
				30	658.5	11	644.9	19	13.6	90		
8	1/364	Налайх дүүрэг	3	90	608.1	-	-	90	608.1	0		
				43	172.5	-	-	43	172.5	0		
				8	35.8	-	-	8	35.8	0		
9		1/365	ГХГЗЗГ	4	4	-	3	-	1.0	-	90	
10	Зөвлөмж		Ерөнхий сайд	3	3	-	2	-	1	-	70	
11			БОАЖСайд	4		-		-		-	65	
	Бүгд			39	4161	11,873.6	1502	2,048.4	2661	10,050.0		

/Эх сурвалж: БОАЖЯ болон бусад холбогдох байгууллагаас ирүүлсэн албан бичиг, биелэлтийн мэдээ/

4.2 Өмнөх аудитаар өгсөн 1 төлбөрийн акт, 8 албан шаардлага, 7 зөвлөмж өгснөөс төлбөрийн актны биелэлт 13.3 хувь, Албан шаардлагын биелэлт 60.7 хувь, зөвлөмжийн хэрэгжилт 67.5 хувьтай байна.

БОАЖЯ-ААС ИРҮҮЛСЭН САНАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

Засгийн газрын II байр, Нэгдсэн Үндэстний гудамж 5/2,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.met.gov.mn

2023.02.09 № 09/777
танай 2023.01.30 ны № 01/149 -т

Санал, тайлбар хүргүүлэх тухай

"Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн нийцэл, үр нөлөө, газар олголт" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна:

- 1.Аудитын дүн 1.4-д "...Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд тухай бүр бүртгэж оруулаагүйгээсгэсэн агуулга нэмэх;
- 2.Аудитын дүн 1.6-д "УИХ-ын 2020 оны 46 дугаар тогтоол гаргуулахад Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 7 ашигт малтмалын зөвшөөрлийн давхцалтай байсныг хасаж арилгасан..." гэж нэмэх;
- 3.Аудитын дүн 1.11-д "...цэгүүдийг тогтоож, масштаб 1:50.000-ны зураглал хийсэн байна." өөрчлөн найруулах;
- 4.Аудитын дүн 2.5-д "Тусгай хамгаалалттай 120 газрын хамгаалалтын менежментийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам 67, орон нутгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар 36, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар 9, төрийн бус байгууллага 7, менежментийн зөвлөл 1-ийг тус тус хариуцаж байна. Менежментийн төлөвлөгөөгүй 37 буюу 84 хувь нь орон нутгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар байна.
- 5.Аудитын дүн 2.6-ын хүснэгт 6-д 2. Хомын талын БЦГ "2,000.0 Колех сан, MAVA" гэж мэдээлэл нэмэх;
- 6.Аудитын дүн 3.10-д "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Байгалийн нөөц газарт хамгаалалтад авсан байгалийн хэв шинж, тодорхой баялгийн төрх байдал, ургамал, амьтны аймгийн байршил, өсөлт, үржилтэд сөрөг, нөлөөгүйгээр уламжлалт аж ахуй эрхэлж болно." гэж уламжлалт мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн гэж нэмэх;
- 7.Аудитын дүн 3.18-д "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 1 дэх хэсэгт Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасан журмыг баримтлан газар ашиглах тухай хүсэлтээ хамгаалалтын захиргаа буюу хамгаалалтын захиргаа байгуулаагүй тусгай хамгаалалттай газар нутагт сүм, дүүргийн Засаг даргад гаргана." гэж нэмэх;
- 8.Зөвлөмж хэсгийн Улсын Их Хуралд толилуулах хэсгийн 2-ыг хасах;
- 9.Зөвлөмж хэсгийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад: 2-ыг "Богдхан уулын дархан цаазат газрын хилийн заагийг УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоолын хавсралтад заасны дагуу тэмдэгжүүлэх." гэж найруулах;
- 10.Зөвлөмж хэсгийн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад: 9. "... менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хяналт үнэлгээ хийх эрх зүйн орчныг бий болгож,..." гэж өөрчлөх саналтай байна.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР
НУТГИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.ЭРДЭМБИЛЭГ

152361390

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР

БОАЖЯ-аас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна.

Үзүүлэлт	Тайлбар
Тайлбар 1	Ирүүлсэн саналыг хүлээн авч, холбогдох мэдээлэл нэмсэн.
Тайлбар 2	Ирүүлсэн саналыг хүлээн авч, холбогдох мэдээлэл нэмсэн.
Тайлбар 3	Ирүүлсэн саналыг хүлээн авч, тайланд холбогдох засвар оруулсан.
Тайлбар 4	Саналыг тусгах шаардлагагүй.
Тайлбар 5	Ирүүлсэн саналыг хүлээн авч, холбогдох мэдээлэл нэмсэн.
Тайлбар 6	Ирүүлсэн саналыг хүлээн авч, холбогдох мэдээлэл нэмсэн.
Тайлбар 7	Тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй ижил утгатай.
Тайлбар 8	Агуулгын өөрчлөлт оруулсан.
Тайлбар 9	Ирүүлсэн саналын агуулга зөвлөмжид байна.
Тайлбар 10	Хүлээн авч холбогдох мэдээлэл нэмсэн.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, хийсэн дүн шинжилгээ аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг”-ээр ТХГН-ийн хязгаарлалтын бүсийг давхардуулан шинэ суурьшлын бүсийг төлөвлөж ТХГНтХ-ийг зөрчсөн байна.
- БОАЖЯ, УУХҮЯ, ГЗБГЗЗГ, АМГТГ зэрэг байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй, мэдээллийн нэгдсэн сан байхгүй, нарийвчилсан зураглалыг Засгийн газраар батлуулаагүйгээс ТХГН-ийн хилийн заагийг тогтоох тухай УИХ-ын 2019 оны 41, 2020 оны 46 дугаар тогтоол хэрэгжихгүй байна.
- Богдхан уулын ДЦГ-ын хилийн заагийг БОАЖЯ-ны 2011 оны зураглалаар 42.2 мянган га, НГЗБА-ны 2012 оны зураглалаар 41.1 мянган га, УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоолын дагуу ГЗБГЗЗГ-ын даргын 2019 оны А/65 тушаалаар 41.4 мянган га, 1997 онд ЮНЕСКО-д бүртгэсэн 41.6 мянган га талбайгаар тус тус тогтоон ашиглаж байгаа нь газрын маргаан үүсгэх шалтгаан болсон байна.
- ТХГН-т газрын ерөнхий төлөвлөгөөгүй, зохион байгуулалтгүйгээр газар олгосон нь газар нутгийг хамгаалах үндсэн зорилтыг хангаагүй, Монгол Улсын нэгдэн орсон Нэгдсэн Үндэстний байгууллагын Биологийн олон янз байдлын тухай конвенцын зорилтыг хангаж чадахгүй байна.
- Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын хэмжээнд газрын кадастрын бодлогыг хэрэгжүүлэх, улсын газрын мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, газрын нэгдмэл сангийн бүх ангиллын газрын улсын бүртгэл, газрын тоо бүртгэл, чанар, үнэлгээ, төлбөр, шилжилт хөдөлгөөн, газар хамгаалах талаар авсан арга хэмжээ зэрэг үзүүлэлтийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж бүрээр тусгах ажлыг хэрэгжүүлэхдээ төрийн бусад байгууллагатай уялдаа холбоогүй ажилласнаас газрын мэдээллийн нэгдмэл санг бүрэн хөтлөөгүй, мэдээлэл зөрүүтэй байна.
- Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хамгаалалтын захиргаа нь зөвшөөрөгдсөн бүсэд ашиглаж болох газар, түүний хэмжээ, байршлыг тогтоогоогүй, газрыг зориулалт бусаар ашигласан, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа зөрчлийг арилгах талаар арга хэмжээ аваагүй, ТEG, ГЗБГЗЗГ, Газар зохион байгуулалтын алба болон шат шатны Засаг дарга нартай уялдаа холбоотой ажиллаж чадаагүй байна.
- ТХГНтХ 1994 онд батлагдаж 1997-2022 оны хооронд 15 удаа нэмэлт өөрчлөлт орсон ч холбогдох харилцааг бүрэн зохицуулаагүй, нийгэм, эдийн засаг, хот төлөвлөлт, хүн амын өсөлт зэрэг өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлэн хуулийг шинэчлэн найруулах шаардлага үүссэн байна.
- ТХГН-т газар ашиглах эрхийн гэрчилгээ авсан хуулийн этгээдийн бүртгэл, дүрмийн санд өөрчлөлт орсон тохиолдолд мэдээлэл солилцох эрх зүйн зохицуулалт байхгүйгээс ТХГНтХ-ийн 33 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт *“Тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын хуулийн этгээд олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулахыг хориглоно”* гэж заасныг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг авч чадахгүй байна.
- ТХГН-ийн хамгаалалтын захиргаад менежментийн төлөвлөгөө боловсруулж батлуулах асуудал хатгалтгүй, түүнийг үнэлж, дүгнэх ажлыг бүрэн хийгээгүй байна.
- ТХГН-ын Хамгаалалтын захиргаа орон нутгийн Засаг захиргааны нэгжтэй харилцан уялдаатай ажиллаж, нутаг дэвсгэрийг хамгаалахад Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасны хувь хэмжээгээр авч, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах боломжийг алдсан байна.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ЗӨВЛӨМЖ

УИХ-д толилуулах нь:

- УИХ тусгай хамгаалалттай газар нутагтай холбоотой тогтоол, шийдвэр гаргахдаа Монгол улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенцын суурь үзэл баримтлалд тулгуурлах;
- Богдхан Уулын Дархан цаазат газрын хилийн цэсийг тогтоохдоо Дэлхийн шим мандлын сүлжээнд бүртгүүлсэн 41,650 га талбайн хэмжээг бууруулахгүйгээр шийдвэрлэхэд анхаарал хандуулах.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдад:

- “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичигт ТХГН-ийн хэмжээг 2025 онд 27 хувьд, 2030 онд 30 хувьд хүргэх зорилтыг хангах чиглэлээрх УИХ-ын тогтоолыг хэрэгжүүлэх;
- Богдхан уулын ДЦГ-ын хилийн заагийг УИХ-ын 1995 оны 26 дугаар тогтоолд заасны дагуу тэмдэгжүүлж эрх бүхий байгууллагаар баталгаажуулах;
- ТХГНтХ-ийн 27 дугаар зүйлийн 27.8-д заасны дагуу суурин газрын ерөнхий төлөвлөгөө, шинээр байгуулах аялал, жуулчлалын бааз, амралт, сувиллын байршил, төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран хянан баталж, зөвшөөрөлгүй буюу зориулалтын бус үйл ажиллагаа явуулж буй иргэн, хуулийн этгээдийн газар ашиглах эрхийг дуусгавар болгох;
- ТХГНтХ-ийг Газрын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлэн шинэчлэн боловсруулж батлуулах;
- ТХГНтХ болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуультай уялдуулсан мэдээлэл солилцох эрх зүйн актыг батлан хэрэгжүүлэх;
- Байгаль, амьтан хамгаалах, газар нутгийнхаа үзэсгэлэнт хэв шинжийг хадгалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн оновчтой хувилбарыг тодорхойлж, олон улсын туршлага, дэвшилтэт технологийг нутагшуулах;
- ТХГН-т үйлчилж байгаа үнэ тарифыг шинэчлэх, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хуваарилуулах, зарцуулах талаар бүх шатны Засаг дарга нартай хамтран ажиллах;
- ТХГН-т газар ашиглагч иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг Газрын нэгдсэн мэдээллийн санд бүрэн оруулж, 2022 оны газар ашиглах гэрээг дүгнэхдээ газрын төлбөр төлсөн эсэх байдлыг харгалзан үзэж, газрын төлбөрийн өмнөх жилүүдийн үлдэгдлийг төвлөрүүлэх талаар хяналт тавьж ажиллах;
- ТХГН-ийн хамгаалалтын захиргааны менежментийн төлөвлөгөө боловсруулах эрх зүйн орчныг бий болгож, олон улсын туршлага, өөрийн орны онцлогт тохируулан боловсруулж батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, удирдлага арга зүйгээр хангах чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх;
- Орон нутгийн болон төрийн захиргааны төв байгууллагуудын хоорондын ажлын уялдаа, харилцан мэдээлэл солилцох, ажлын хариуцлага, хяналтыг сайжруулж, байгаль орчныг хамгаалах талаар хуулийн хэрэгжилт болон өмнөх аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангах.

ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

№	Илэрсэн зөрчлийн утга	Дүн /сая.төг/	Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төслийн хүрээнд худалдан авсан 93.1 сая төгрөгийн Тоёото ланд круйзер автомашин эзэмших гэрчилгээ нь ТББ-ын нэр дээр бүртгэлтэй, 110.0 сая төгрөгийн дизель хөдөлгүүрийг БОАЖЯ-ны санхүүгийн тайланд бүртгээгүй байна.	203.1			1	203.1		
2	2020-2022 оны байдлаар БУДЦГ-т 1317 иргэн, хуулийн этгээдийн 1445 нэгж талбарын газрын төлбөр 40,853.5 сая, Горхи-Тэрэлжийн БЦГ-т 715 иргэн, хуулийн этгээдийн 1488 нэгж талбарын газрын төлбөр 1,089.9 сая нийт 41,943.4 сая төгрөгийн төлөгдөөгүй үлдэгдэлтэй байна.	41,943.4	2	41,943.4				
3	Газар ашиглах эрхийн хугацаа дууссан БУДЦГ-т 33 иргэн, хуулийн этгээд 1,050.6 сая, Горхи-Тэрэлжийн БЦГ-т 34 иргэн, хуулийн этгээд 68.9 сая нийт 1,119.5 сая төгрөгийн газрын төлбөрийг төлөөгүй байна.	1,119.5			1	1,119.5		
4	ТХГН-т газар ашиглуулахаар шийдвэрлэсэн иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг ГЗБГЗЗГ-ын цахим системд орсон газрын төлбөрийн мэдээлэлтэй тулгаж үзэхэд Горхи-Тэрэлжийн БЦГ-ын нэр бүхий 152 иргэн, хуулийн этгээдийн 237.1 га газар, Хөвсгөл нуурын БЦГ-ын 56 нэгж талбарын мэдээллийг оруулаагүйгээс Газрын төлбөрийн тухай хуулийн 4-д газрын төлбөрийн нэхэмжлэл үүсгэн, ногдуулалт хийгээгүй байна.				1	-		
5	БОАЖЯ-наас олгож буй тусгай хамгаалалттай газарт нутаг дэвсгэрт газар ашиглах гэрчилгээ гарсан боловч Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.11 дэх заалтын дагуу улсын тэмдэгтийн хураамжийг төлөөгүй, гэрчилгээгээ аваагүй 28 иргэн, хуулийн этгээд байна.	807.0	1	807.0				
6	БОАЖЯ нь Дархан цаазат болон Байгалийн цогцолбор газрын тодорхой хэсгийг иргэн, хуулийн этгээдэд гэрээний үндсэн дээр ашиглуулахаар заасан боловч аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нар эрх мэдлээ хэтрүүлэн 967 иргэн хуулийн этгээдэд эзэмших эрхийн гэрчилгээ, 1293 иргэн хуулийн этгээдэд өмчлөх эрх олгосон нь ТХГНХ-д заагаагүй эрх эдэлж хязгаарлалтын бүсийн дэглэмийг зөрчсөн.				1	-		
7	БОАЖЯ нь ТХГНХ-ийн 27 дугаар зүйлийн 27.8 -д заасны дагуу суурин газрын ерөнхий төлөвлөгөө, шинээр байгуулах аялал, жуулчлалын бааз, амралт, сувиллын байршил, төслийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран хянан батлаагүй байна.							1

8	УТХГН-ийн зөвшөөрөгдсөн бүсэд иргэн, хуулийн этгээдэд газар ашиглуулах зөвшөөрөл олгоход тавих шалгуур, шалгаруулалтын талаар тодорхой зохицуулалтгүйгээс тус бүсэд газар ашиглуулах үйл ажиллагаанд Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан "газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах" зарчим хэрэгжихгүй байна.							1
9	Богдхан уулын ДЦГ-ын хязгаарлалтын бүс болох Нүхтийн аманд Тэс петролиум ХХК шатахуун түгээх станц ажиллуулж байгаа нь газрын мэдээллийн нэгдсэн сан болон харьяа дүүргийн татварын хэлтэст бүртгэлгүй, газрын төлбөр төлөхгүйгээр үйл ажиллагаа явуулж байна.				1	-		
10	ТХГН-т газар ашиглах зөвшөөрлийн хугацааг сунгуулаагүйгээс нэхэмжлэл үүсээгүй, төлбөр авах боломжгүй болсон учир дээрх 86 иргэн, аж ахуйн нэгжээс 2020-2022 онд 1,172.4 сая төгрөгийн газрын төлбөрийг ногдуулах боломжгүй болсон байна. Энэ нь газар ашиглагч иргэд цаг тухайд нь газрын зөвшөөрөл сунгуулах үүргээ биелүүлээгүй, хамгаалалтын захиргаанаас шаардлага тавиагүй, заавал цахим программаар нэхэмжлэл үүсгэж байж төлбөр авах эрх үүсдэгтэй холбоотой байна.							1
11	ТХГН-т газар ашиглах эрхийн гэрчилгээ авсан иргэн, хуулийн этгээдийн тоо БОАЖЯ-ний мэдээллээр 2014, ГЗБГЗЗГ судалгаагаар 2286 байгаа нь Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1. 9 дүгээр зүйлийн 9.1.1, 23 дугаар зүйлийн 23.2.14. 23.2.22. 26 дугаар зүйлийн 26.2-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хоорондын ажлын уялдаа холбоогүй, хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж ирсэнтэй холбоотой байна.							1
12	ТХГН-т аялал жуулчлалын зориулалтаар үйл ажиллагаа явуулсан 2019 онд 294, 2020 онд 301, 2021 онд 303 иргэн, хуулийн этгээд тайлант хугацаанд нийт 44 нь БОАЖЯ-д байгаль орчны менежментийн төлөвлөгөөг ирүүлж батлуулсан боловч үлдсэн 90 гаруй хувь нь ирүүлээгүй, харьяалах орон нутгийн болон хамгаалалтын захиргаанд хүргүүлж биелэлтийг тайлагнаагүй, түүнийг үнэлж, дүгнэх ажил бүрэн хийгдээгүй, сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн тусгай дансанд барьцаа хөрөнгө төвлөрүүлээгүй байна. Энэ нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3, 9.8, 9.9 дэх заалтууд, 14 дүгээр зүйлийн 14.1.2-т заасныг тус тус хэрэгжүүлээгүй байна.					1	-	
	ДҮН	44073.0	3	42750.4	5	1323.6	-	4

[illegible]

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.